6.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй.....39

6.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль эрх зүйн орчин...42

6.3 MNS ISO OHSAS 18001:2012 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандартын хэрэглээ.....44

## **БҮЛЭГ VII. БАЙГАЛЬ ОРЧИН, ЭКОЛОГИЙН ҮНЭЛГЭЭ.....45**

7.1 Байгаль орчныг хамгаалах хууль эрхзүйн орчин.....46

## **ОРШИЛ**

Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумдын нутагт орших Үзүүрт нэртэй талбайн “Жалга-2”, “Жалга-3” алтны шороон ордын MV-022144 тоот, ГУУКХ-ийн даргын 2022 оны 07 сарын 07-ны өдрийн 311 тоот шийдвэрээр олгосон.

Үзүүрт нэртэй талбайн “Жалга-2”, “Жалга-3” алтны шороон ордод 2020-2021 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн гаргасан ХХ-06-05 тоот дүгнэлт, Үндэсний геологийн албаны даргын 2022 оны 06 дугаар сарын 07-ний өдрийн Н-49-р дугаар тушаалын дагуу бодитой болон боломжтой нөөцөд тулгуурлан түүнийг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах боломжтой гэж үзсэн.

Үзүүрт нэртэй талбайн “Жалга-2”, “Жалга-3” алтны шороон орд нь III бүлэгт хамаарах бөгөөд ордын хэмжээнд тогтоогдсон алтны боломжтой нөөц С зэрэглэлийн химийн цэврээр нийт 10.5 кг байна. Ордын хэмжээнд хөрсний дундаж зузаан 1.4 м, элсний дундаж зузаан 0.4 м, дундаж агуулга  $167 \text{ мг/м}^3$  болно.



### ***Байриил, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээлэл***

***Байриил:*** Төслийн талбай нь Баянхонгор аймгийн Өлзийт, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумдын нутагт Таацын голын сав газарт оршино.

Геологи хайгуулын ажил явуулсан талбай нь “Үзүүрт” нэртэй MV-022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн 1027.27 га бүхий талбайг хамран байр зургийн L-47-83 хавтгайд байрлана.



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ, БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН  
 НУТАГТ ОРШИХ "ҮЗҮҮРТ" НЭРТЭЙ ТУСТАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ТАЛБАЙН  
 БАЙРШЛЫН ЗУРАГ



Тусгай зөвшөөрлийн байршил

Баянхонгор, Өвөрхангай аймгийн Өлзийт, Нарийнтээл сумдын нутагт орших Үзүүрт талбайн “Жалга-2”, “Жалга-3” алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл

## БҮЛЭГ I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### 1.1 Төслийн зорилго

Үзүүрт нэртэй талбайн “Жалга-2”, “Жалга-3” алтны шороон ордын нөөцийн ил аргаар ашиглах Техник-эдийн засгийн үндэслэлийн гол зорилго нь ажилчдыг ажлын байраар хангах, алт олборлон эдийн засгийн эргэлтэд оруулах, Монгол улсын валютын нөөц бүрдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулахад оршино.

### 1.2 Бүс нутгийн дэд бүтэц

**Уул зүйн хувьд:** Талбай нь Хангайн нурууны өмнөд салбар уулс болох Өшгөгийн нурууны баруун хэсэг, Зүүн, Баруун Уушигийн хад (2062.0-2059.3 м), Задгайн урд нуруу, Цоохор, Сүвээ, Чулуун онгоцот, Өндөр дэнж (2076 м), Баян (2173 м), Хар нүдэн (2076 м), Шанд, Бөтөө, Авзага (1746.8 м), Луугар (1606.9 м), Олон Овооны хүрмэн бэгэлцэг тээг нуруунууд тэдгээрийн хоорондох хөндийнүүдийг хамаарч байна. Мөн талбайн хойт хэсэгт Модотын сэрвэн (2279.6 м), Сэртэн, Зүүн харганын болон Өлзийт овооны нурууд оршино.

Тусгай зөвшөөрлийн талбайн зүүн өмнөд хэсэгт орших Өшгөгийн нуруу нь баруунаас баруун хойшоо чиглэлтэй сунаж тогтсон 15-20 км өргөн 50 гаруй км урт байдаг. Үнэмлэхүй өндөр нь 1950-2150 м-д хэлбэлзэх ба тус талбайд хамаарч байгаа баруун хэсэгтээ хамгийн өндөр орой нь Өвөр-Ашнайн уул (2127 м) юм. Өшгөгийн нуруу нь ар өвөрлүүгээ олон тооны хуурай сайр, жалга, нарийн хөндийнүүдээр хэрчигдсэн байх ба намхавтар хадан хавцал, жалга судагтай, оройгоороо ихэвчлэн базальтын хучлагат тэгш хавтгай хэлбэртэй юм.

Таацын голын зүүн хажуу нь заримдаа нилээд эгц цавчим хадан хавцал үүсгэсэн байна. Өшгөгийн нурууны баруун хэсэг нь дийлэнхдээ хүрмийн хучаасаар хучигдсан тэгш ширээ хэлбэртэй Шахалгын тээг, Өнцгийн тээг, Хүнхрээгийн дэнж, Магнайн дэнж, Барчингийн тээг гэх мэт нуруудаас бүрдэнэ.

Талбайн баруун хэсэгт Таац, Түйн голуудын хоорондох талбайд 1606.9-2173.0 м үнэмлэхүй өндөртэй тэгш хавтгай оройтой хүрмэн бэгэлцэг, уул нурууд зонхилж байна. Эдгээр нурууд нь ихэвчлэн баруун хойноос урагшаа чиглэлтэй 1.5-6 км өргөн 35 км хүртэл урт үргэлжилнэ. Мөн нуруунуудын аль нэг төгсгөл юм уу хажуугийн хэсэгт нь Хүрэн овоо, Хүйс, Тэвшийн тахилга, Зүүн шийр зэрэг жижиг шток хэлбэрийн сууриараараа 500-аад м өргөнтэй 2000-2100 м өндөртэй базальтаас бүтсэн өндөрлөгүүд ажиглагдана.

Талбайн хойд хэсэгт Модотын сэрвэн (2279.6 м), Сэртэн (2231.6 м), Зүүн харгана (2046.9 м), Өлзийт овоо (2201.0 м) зэрэг сэрэвгэр хадан оройтой намхан бэсрэг уул нурууд тэмдэглэгдэж байна. Эдгээр уул нурууд нь Эрдэнэ, Сангийн далайн сайр, Өвөр хүйтэн, Бүдүүн, Байн, Хашаат, Хар нүдэн, Бөтөө, Луугар, Шанд, Гашууны тээг зэрэг хөндий хоолойнуудаар тусгаарлагдана.

Талбай нь *ус зүйн хувьд* Төв Азийн гадагш урсгалгүй ай савд, Монгол орны гидро-геологийн мужлалаар Хойд Монголын гидрогеологийн системийн грунтын ус зонхилсон Онги, Таацын голын сав газрын Таацын голын дэд сав газарт хамаарна. Судалгааны талбайд урсгал устай гол байхгүй ба талбайн дүүргийн хэмжээнд байнгын урсгалтай Таацын гол болон Худаг урт, Хөөтийн задгай гэх 2 булаг, олон тооны энгийн болон уурхайн худаг байна.

Таацын гол Хангай нуруунаас эх авч тус талбайн зүүн хэсгээр хойноос урагшаа нэвт дайран урсаж өнгөрнө. Уг голын ерөнхий урсгалын урт нь 180 км хийгээд зүүн Богд уулын ард Таацын цагаан нуурд цутгана. Зарим гантай жилд усны хэмжээ нь багасаж нуураас дээш 20 гаруй км-г шургаж орно. Голын хөндий урсгалын дунд хэсэгтээ нилээд нарийн V хэлбэртэй, харин Цагаан овооноос доош уужимсаж хэлбэртэй 800 гаруй м өргөн болно. Гольдролын өргөн 7.8-12 м-д хэлбэлзэнэ. Усны гүн судалгааны талбайн хэсэгт 7, 8, 9-р саруудад үерлээгүй үедээ 0.2-0.3 м байна. Бороо ихтэй жилд 6, 7, 8-р саруудад үерлэж усны түвшин үлэмж нэмэгдэнэ.

Худаг урт, Хөөтийн задгайн булгууд нь 1.2-2 км урт 0.5 м өргөнтэй усны гүн 4-5 см. Урсгал нь адаг руугаа сайрд шургаж орно.

Талбайн дүүрэг орчимд нийтдээ 40 гаруй энгийн болон уурхайн худаг ашиглагдаж байгаа ба нийт талбайд харьцангуй жигд тархалттай юм. Эдгээр худгуудаас жилийн 4 улиралд малчид ашиглаж байна

Тухайн жилийн хур тунадасны хэмжээнээс хамаарч нуур, тойром, худгийн усны түвшин өөрчлөгдөнө. Цас их унаж хайлах, үргэлжилсэн ширүүн бороотой үед хотос хонхор, тойромууд нь устай болох ба хуурай сайруудаар нь ус урсаж, бороо хур татрахад усгүй болно. Хүн малын ундаанд зөвхөн булаг, худгийн усыг хэрэглэх бөгөөд худгуудыг хуурай сайр, хөндий, тойрмын зах хавийг бараадуулан гаргасан. Худгийн усны түвшин гадаргуугаас 1-3 м заримдаа 5-7 м байдаг.

Орд нь Таацын голын баруун цутгал болох Билгэхийн хөндийд байрлах ба уг хөндий нь өндөр хясаагаар хүрээлэгдсэн, өргөн нь, 100-150 м, голын гольдролын өргөн 5.0-10.0 м, дундаж гүн нь 2.5 м хүрдэг хуурай сайраас тогтоно. Газар доорх усны урсацын нийт хэмжээ 3.3 л/сек. Голууд нь 10-р сарын сүүлчээр хөлдөж, 4-р сард гэснэ.

Судалгааны талбайн газар зүй, ландшафт нь хээр талын бүсд хамаарна. Энд ихэвчлэн бэсрэг уул нуруудын бэл хормой, тал хээр, хөндийн делюви, пролювийн жижиг хайрга агуулсан элсэнцэр, цайвар бор саарал, бор шаргал хөрс зонхилно. Хөрсний үеийн зузаан нь 0.2- 0.1 м.

*Амьтан ургамлын аймаг:* Ургамалын хувьд модлог ургамал тун ховор ба хээр, талын өвслөг ургамал зонхилно. Үүнд: хялгана, ерхөг, таана, шувуун хөл, тарваган шийр, хээрийн цахилдаг, хазаар, сазаг, далан хальс зонхилно. Мөн өргөст болон бутлаг хамхаг бусад шарилж ургана. Хөндийн зарим тохой татам дагаж дэрс, хиаг ургах ба Өшгөгийн нурууны болон талбайн төв хэсгийн хүрмэн бэгэлцэгүүдийн бэлээр явган харгана, алтан харгана сийрэг тархалттай ургана. Мөн талбайн өмнөд хэсгийн хөндий, хүрмийн бэлд бор, улаан бударгана, баглуур, тэсэг ургана.

Таацын голын эрэг, хөндийгээр хэсэг хэсэг дэрс, цахилдаг, ширэг ургадаг ба мөн голын Уулангийн хавцгайд бор бургас, баруун зүүн талын аараг толгод болон сайр жалгын хөвөөгөөр бор харганын бут сийрэг тархалттай ургасан байдаг.

Судалгааны талбайд уул хээрийн, тал хээрийн бүсийн амьтад зонхилон амьдарна. Үүнд: тарвага, зурам, үхэр оготоно, зараа, алаг даага мэт мэрэгчид байна. Энэ бүс нутагт сүүлийн жилүүдэд үлийн цагаан оготоно үлэмж өсөж билчээр сүйтгэн нилээд хохирол учруулж байгаа юм. Үнэг, хярс, мануул, өмхий хүрэн, чоно зэрэг араатан амьтад нутаглана. Өшгөгийн нурууны баруун болон өврөөр Таацын голын хоёр талын аараг толгод, Хүрмэн нурууны хэсэгт нилээд тооны аргаль нутаглана. Таацын голын сав нутгаар дулааны улиралд ангир голдуу усны шувууд ирнэ. Тас, шар шувуу, сар, ууль, бор болжмор, ятуу, ногтруу зэрэг шувууд амьдарна.

**Цаг уур:** Хайгуулын талбайд хамаарч байгаа Хангайн нурууны өврийн салбар, намхан уулс болон толгодорхог гадаргуутай аараг, Таац, Түйн голуудын сав нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, хоногийн болоод жилийн дулаан хүйтний зөрүү их, урт хүйтэн өвөлтэй, зун нь богинохон жилдээ харьцангуй бага хур тунадас унадаг, хаврын улиралд хүчтэй салхи шуургатай байдаг ба жилийн ихэнхдээ нартай цэлмэг өдөр зонхилдог нутаг юм. Тус талбайн цаг уурын хэмжигдхүүнийг үндэслэн авч үзвэл хамгийн халуун нь 6-р сард 15-22.3° хамгийн хүйтэн нь 1-р сард 26.1° хэлбэлздэг байна. Агаарын жилийн дундаж хэм -0.62-44° хэлбэлзэнэ.

Жилд унах хур тунадасны хэмжээ 23.4-429.9 мм ба ихэнх нь тухайлбал 75 орчим хувь нь зуны сүүлч намрын улиралд унана. Өвөлдөө 5-10 см зузаан цасан бүрхүүл тогтдог. Зарим өвөл 20-25 см зузаан цас унах нь бий, Агаарын чийглэг багатай, Сарын дунджаар 28 хувь, жилийн дундаж нь 75 хувь байна. Хаврын улиралд ихэвчлэн салхи шуургатай. Ялангуяа 4-р сард болон 5-р сарын эхээр хүчтэй шороон шуурга тавих нь олонтой. Салхи ихэвчлэн баруун, баруун хойноос шуурна. Салхины дундаж хурд 4-9 м/сек ба хүчтэй шуурганы үед 20 м/сек хүрэх нь бий. Цаг агаарын хамгийн тааламжтай үе нь намрын улирал байдаг. Намартаа салхи шуургагүй, агаар тогтуун, чийглэг ургамал ногооны шим гүйцэж, цаг уурын нөхцөл жигд тэгширдэг нь сүүлийн жилүүдийн онцлог юм. Намрын сүүл сарын агаарын хэм жигд буурсаар өвөлд шилжинэ. Сүүлийн 10 жилийн байдлаар тус бүс нутагт өвөл нь харьцангуй дулаан, нэг өвөл огт цасгүй, 3 өвөл нь харьцангуй их цастай, 6 өвөл нь хэвийн хэмжээний цасан бүрхүүлтэй байсан байна.

**Дэд бүтэц:** Зам харилцааны хувьд тус район нь ажил явуулах нөхцөл сайтайд тооцогдоно. Энэ бүс нутаг нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баруун баян улаан, Баянхонгор аймгийн Өлзийт, Богд сумуудын нутгийн уулзвар хэсэг юм. Тус бүс нутаг нь хээр талын өвслөг ургамалтай, талбайд жигд тархсан ардын худаг олонтой, мөн Таац, Түйн голуудын сав нутаг учир таван хошуу малын үлэмж тохиромжтой нутаг юм. Иймд дээрхи сумуудын ардын аж ахуйтан малчдын жилийн 4 улиралд байнга тогтмол нутагладаг харьцангуй олон айл өрх нутагшсан олон мянган мал билчээрлэн идээшсэн нутаг байна.



Талбайн зүүн захад Баянтээгийн нүүрсний уурхай ажиллана. Уг уурхайгаас Баянхонгор аймагт нүүрс тээвэрлэдэг гол зам, мөн талбайн хойт хэсгээр Улаанбаатараас баруун аймгуудын чиглэлийн төв зам тус тус дайрч гарна.

Тус талбайд төв суурин газар байхгүй хэдий ч эргэн тойронд нь Өлзийт, Жинст, Богд, Баруун баян улаан, Баянтээг, Нарийнтээл зэрэг сумын төвүүд 20-60 км-ийн тойрогт байрласан байна. Хамгийн ойр сумын төв болох Нарийнтээл суманд соёлын төв, хүнсний жижиг үйлдвэр, сумын хүний болон мал эмнэлэгийн салбар, 9 жилийн дунд сургууль, ХААН банк, АТС холбооны станц, (үүрэн телефоны G mobile сүлжээ уурхайгаас чөлөөтэй холбогдоно) шатахуун түгээх станц ажилладаг.

## БҮЛЭГ II. ОРДЫН ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮР ДҮН

### 2.1 Геологи судалгааны түүх

Хайгуулын талбай нь геологийн судалгааны хувьд харьцангуйгаар 1:200000-ны масштабтай бүлэгчилэн зураглалын ажил, 1:50000 ны масштабтай геологийн зураглал- ерөнхий эрлийн ажлаар үе шаттай судлагдсан нутаг дэвсгэр бөгөөд сэдэвчилсэн судалгаанууд ч их хийгдсэн байдаг.

*1:200000-ны масштабтай геологийн зураглалын ажил:*

1982-1984 онд Д.Тогтох нарын гүйцэтгэсэн 1:200 000-ны масштабын бүлэгчилсэн зураглалын ажлын талбайд судалгааны талбай бүхэлдээ хамрагдсан. Энэ ажлаар өмнөх судлаачдын тухайн үеийн түвшинд янз янзаар ангилж байсан давхаргазүйн нэгжүүдийн ангилалыг өөрсдийн судалгаа болон сэдэвчилсэн судалгааны ажлуудтай нэгтгэн системчилснээр бүс нутгийн геологийн тогтоц, металлогений талаархи ойлголтыг шинэ түвшинд гаргасан. Үүгээр өмнөх Е.Д.Аносова, зэрэгцээ талбайд А.Ф.Бойшенко нарын дунд протерозой, доод кембри, силурт хамааруулж байсан хурдсыг доод-дунд рифейн жирэмийн нуруу сери нэртэйгээр ялган дотор нь 2000 м зузаантай вулканоген-занарын дээд, 2400-2500 м зузаантай цахиурлаг-вулканоген- ногоон занарын дунд, 3000 м гаруй зузаантай элсжин-занарын доод зузаалгуудад хуваасан ба насны үндэслэлийг нь Зээргэнтийн нурууны дүүрэгт оорцог формацын карбонат чулуулгаар нийцлэгээр хучигдсан гэж үзсэн байна.

Төслийн талбайн баруун талд залган Л.В.Заботкин нар 1984-1987онд 1:200 000-ны масштабын бүлэгчилсэн зураглалын ажлыг хийж гүйцэтгэсэн байдаг. Энэ ажлаар манай талбайд мезо, неопротерозой (хэдрэг, гуч формац) гэж зураглагдсантай адил төрлийн хурдсыг доод-дунд рифейн Бүрд голын серид, төслийн талбайд эдиакариа-доод кембрийн Баянхонгор формацад хамааруулсан хурдсын шууд үргэлжлэлийг венд-доод кембрийн Өлзийт гол формацад, Хангай бүрдэлд ангилсан боржинлогийг түүрүү пермийн Улаагчин бүрдэлд хамааруулжээ.

1986-1988 онд Ц.Баярсайхан нар Хангайн нурууны баруун хойд хэсэгт Байдраг, Тэрхийн голуудын эхээр, 1986-1990 онд С.Гүрцоо нар Хангайн нурууны зүүн хэсэгт, 1988-1990 онд

Ч.Төмөрчөдөр нар Хангайн нурууны өмнөд хэсэгт 1:200000-ны масштабын геологийн зураглалын ажил гүйцэтгэхдээ Хангайн серийн ангилалыг өөрчилж Эрдэнэцогт давхаргадсыг доод-дунд девонд, Цэцэрлэг давхаргадсыг дунд-дээд девонд, Жаргалант давхаргадсыг доод карбонд, Байдраг давхаргадсыг дунд-дээд карбонд тус тус хамааруулан Гольденберг нарын ялгасан стратотипийг өөрчилсөн зүсэлтүүд хийсэн ба өмнөх судалгаагаар бүх давхаргадаст яшма байсныг өөрчлөн улаан хасын томоохон үетэй хэсгүүдийг Эрдэнэцогт формацад хамаатуулан яшмаас авсан палеонтологийн үлдвэрээр нас нь доод-дунд девонд хамаардагийг тогтоосон. Үүнээс хойшхи цаг үед хийгдсэн зураглалын ажлуудад Хангай группийн хурдсын давхарга зүйн ангилалд дээр дурдсан схемийг баримталдаг болжээ.

*1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил:*

Судалгааны талбайн баруун урд захын L-48-73-B хавтгайтай залгаа хэсэгт Ч.Сүхбат, Н.Баярхүү нар 1989-1990 онд 1:50000-ны масштабын геологийн зураглалын ажил явуулан Л.В.Заботкины ангилалыг зарчмын хувьд өөрчлөөгүй ба манай төслийн талбайд эдиакариа-доод кембрийн Баянхонгор формацаар зураглагдсан хурдсын баруун үргэлжлэлийг венд-доод кембрийн Өлзийт голын свитэд ялгаж дотор нь 3 дэд свитэд хуваажээ. Боржинлог чулуулгуудыг Хангай бүрдэлд хамааруулсан нь Могойт хайрханы талбайн ангилалтай дүйж байна.

Төслийн талбайгаас хойш, Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт 1990-1992 онд Ш.Лхүндэв, Ч.Төмөрчөдөр нар 1:50000-ны масштабын геологийн зураглалын ажил гүйцэтгэж Хангай группийн хурдсын ангилалын талаар Д.Тогтох нарын хийсэн схемийг өөрчлөн Хангайн бүс нутагт нийтээр хийдэг ангилалд нийцүүлэн хийжээ. Тухайлбал Д.Тогтох нарын ялгасан доод-дунд девоны Ханхар свитийг Эрдэнэцогт формацад, дунд-дээд девоны Цоройдог свитийг Цэцэрлэг формацад, доод карбоны Дулаанхайрхан формацыг Жаргалант формацад тус тус хамааруулсан ба ер нь Эрдэнэцогт формацын ялгах гол шинж нь улаан яшмын тэмдэгт үеүд ба суурилаг вулканитийн жижиг үеүд гэж үзсэн байна.

Төслийн талбайн хэмжээнд 1994-1995 онд И.Ниндэвгомбо, Ч.Сүхбат нарын Түй, Таацын голуудын хоорон дахь сав газарт явуулсан 1:50000-ны масштабтай геологийн бүлэгчилсэн зураглалын ажилд бүрэн хамрагдсан байна./Ф-5009/. Энэ ажлын үр дүнг ашиглан тулгуур материал болгон ашиглав.

2021 оноос “Империо майнинг” ХХК алтны Баянхонгорын бүсийн Таацын голын баруун биед орших “Үзүүрт” нэртэй хайгуулын талбайд хайгуул, судалгааны ажил явуулж байна.

*Геофизикийн судалгааны түүх:*

Төслийн талбай нь 1: 500000 масштабын хүндийн хүчний, 1: 200000 масштабын агаарын геофизикийн судалгаануудаар бүрэн бүрхэгдсэн бөгөөд харин 1: 200 000 масштабын агаарын соронзон зураглалаар талбайн баруун хагас нь (L-48-73) судлагдсан байна.

## 2.2. Дүүргийн ба ордын геологийн тогтоц

Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Төв Монголын металлогений мужийн Байдраг, Баянхонгорын структур-формацийн бүсэд хамаарагдах бөгөөд давхарга зүйн хувьд доод протерозойгоос дөрөвдөгч хүртэлх насны хувирмал, тунамал, тунамал-вул-каноген хурдас мөн бялхмал болон гүний чулуулгууд тархжээ.

Байдрагийн структур формацийн бүсэд доод протерозойн хувирмал чулуулгууд-аас тогтох Бөмбөгөрийн бүрдэл, доод-дунд рифейн тунамал хурдсаас бүрэлдсэн Бүрд-ийн голын, доод-дунд девоны терриген Хүрэн толгойн, доод пермийн вулканоген тунамал чулуулгаас тогтох Хар Аргалантын давхаргадасууд тус тус тархдаг.

Баянхонгорын бүсэд офиолит зүсэлтийн дээд хэсэг болох венд-кембрийн тунамал вулканоген чулуулгуудаас тогтох Өлзийт голын давхаргадас голлон илэрдэг.

*Давхарга зүй:* Доод протерозой. Бөмбөгөр формац (PR1 bm)

Доод протерозойн метаморф хурдас нь Байдрагийн блокт тархдаг бөгөөд судалгааны талбайн хэмжээнд тогтоогдсон хамгийн эртний настай чулуулаг юм. Энэхүү хувирмал чулуулгууд нь Өшгөгийн нурууны төв хэсгээс Түйн голын баруун эрэг хүртэл 15 км урт, 3-5 км өргөн гаршыг үүсгэн баруун хойш суналтай тектоникийн блокууд илэрсэн байдаг.

Доктор Ө.Төмөртоогоо (1989) өөрийн бүтээлдээ архейн Байдраг, доод протерозойн Бөмбөгөрийн бүрдэлээс гадна дээд протерозойн Таацын голын бүрдэлийг шинээр ялгасан байдаг. Сүүлийн үеийн судалгааны материалууд болон өөрсдийн судалгааны үр дүнгээр И.Ниндэвгомбо, Ч.Сүхбат нар судалгааны талбайд тархсан хувирмал чулуулгийг доод протерозойн Бөмбөгөрийн бүрдэлтэй адилтган литологийн найрлагаар нь дотор нь 3 зузаалагт ангилсан байна. Үүнд:

Доод зузаалаг-цахиурлаг, плагиоклазат болон 2 гялтагнуурт, биотит гнейс, амфи-болит;  
Дунд зузаалаг-доломит, гантиг, занар, гнейс, амфиболит;  
Дээд зузаалаг-занар зэргээс тус тус тогтоно.

Доод протерозойн хувирмал комплекс нь тектоник маагмын үйл ажиллагаанд олон удаа өртөж тасралт эвдрэл, атираажилтанд хүчтэй автагдсаны улмаас чулуулгийн харилцан байршлын дараалал, хоорондын харьцаа, анхдагч зузааныг тогтоох боломжгүй болсон байна.

Доод зузаалаг ( PR1 bm1): нь судалгааны талбайн төв хэсэгт хойт талаараа Өмнөт Баянхонгорын гүний хагарлаар венд кембрийн хурдсаас тусгаарлагдан Баянтээгийн баруун талаас Түйн голын баруун эрэг хүртлэх бүс нутагт дунджаар 2.5 км өргөнтэй, 10-15 км урттай баруун хойш сунасан тектоникийн блокуудад илэрдэг. Энд доод зузаалаг нь гялтагнуурт, хоёр гялтагнуурт гнейс, биотит, цахир, плагиоклазат занар, доломит, амфиболитоос бүрдэнэ. Эдгээр нь мигматитад хувирсан байх ба өмнөх судлаачид энэ хурдсыг дээд рифейд

хамааруулж үзсэн байсан. Мөн энэ зузаалагтай хүчтэй грейзенжиж хувирсан, лейкократ плагиоборжингийн 0.8-2.6 м хүртэл зузаантай нийцлэг дайкууд холбоотой байдаг.

Бэлгих толгойгоос зүүн урагш 2.5 км-т хийсэн доод зузаалгийн хэсэгчилсэн зүсэлтийг доороос дээш нь авч үзвэл:

1. Бор саарал өнгийн мигматитжсан цахир-биотит-плагиоклазат мөхлөгт гнейс.....300 м
2. Жижиг мөхлөгт, хөх саарал өнгийн гялтагнуур, биотитот гнейс ..... 2 м
3. Цайвар саарал өнгийн, жижиг мөхлөгт гантиг ..... 80 м
4. Жижиг мөхлөгт хөх саарал өнгийн гялтагнуур, биотитот гнейс ..... 320 м
5. Цайвар саарал өнгийн, дунд мөхлөгтэй,цахир- биотит-гялтагнуурт гнейс-.....250 м
6. Хөх саарал өнгийн, жижиг мөхлөгт, гялтагнуур биотитот гнейсийн үетэй (30 м), цайвар саарал өнгийн, дунд мөхлөгт, цахир биотит-жоншт гнейс..... 250 м

Эдгээр нь аплит, заримдаа пегматит бүтэцтэй ногоон саарал лейкократ боржингийн (1.5-3 м зузаантай), нийцлэг байрлалтай биетээр зүсэгдсэн байдаг. Зүсэлтийн нийт зузаан 1520 м.

Дээрхи зүсэлтээс баруун хойш Түйн голын зүүн эрэгт Тэвшийн тахилга уулаас зүүн тийш Бөмбөгөрийн бүрдэлийн доод зузаалагт хамаарах хурдас нь цайвар шаргал өнгийн гялтагнуурт цахиржингийн нарийн үе, жижиг мөхлөгт, цайвар саарал өнгийн хоёр гялтагнуурт гнейс, анар бүхий хар саарал өнгийн амфиболитийн 6-8 м бүхий зузаантай үе, хар саарал өнгийн биотитот гнейс зэргийн салаавчилалаас тогтох ба эдгээр нь нийцлэг байрлалтай, хожуу рифейн лейкократ плагиоборжингийн силл, дайкуудаар зүсэгдсэн байхын зэрэгцээ цахирын судлаар хэрчигдсэн байдаг. Энд чулуулгийн гарш муу, зөвхөн амфиболит, боржингийн илрэлүүд гнейсийг бодвол арай илүү илэрсэн байдаг учраас энд доод зузаалгын зүсэлтийг зохиох боломжгүй байлаа.

Дунд зузаалаг (PR1 bm2):нь ерөнхийдөө доод зузаалагтайгаа хамт илрэх бөгөөд хоорондоо аажим шилжилттэй байдаг. Дунд зузаалаг нь ихэвчлэн тод цагаан өнгийн, янз бүрийн зузаантай гантигийн үетэй биотитот-гялтагнуурт болон биотитот занар, боржин гнейс, эвэр хуурмагт занар, амфиболитийн багц үе зэргээс тогтоно. Өшгөгийн нурууны баруун хэсэг, Таацын голын дунд хэсгээр илэрсэн дунд зузаалаг нь хожуу рифейн плагиоборжингоор их хэмжээгээр зүсэгдэж, тасралтат эвдрэлд их өртсөн бөгөөд ихэнхдээ боржингийн массивийн дунд нарийн зурвас болон үлдэц маягтайгаар илэрдэг.

Өвөр Ашнайн уулын орчимд цагаан шаргал өнгийн гантигжсан доломитын янз бүрийн зузаантай үеүүд биотит-гялтагнуурт болон биотит боржин гнейс, амфиболит, пироксен-плагиоклазын занарын үеүүдтэй салаавчилсан байдаг. Энд мөн плагио боржингийн олон тооны биетүүд зүссэн байх ба эдгээр нь хагарлаар хэрчигдэж олон тооны жижиг блокуудад хуваагдсанаас байрлал нь тодорхойгүй болсон байдаг.

Дунд зузаалгийн харьцангуй бүрэн зүсэлт судалгааны талбайн баруун талын Зүүн шийрийн шанд худгийн орчимд хийснийг доороос дээш үзүүлбэл:



1. Тод цагаан өнгийн, дунд мөхлөгт, нягт цул текстуртэй гантиг.....	250 м
2. Цайвар саарал өнгийн, дунд ширхэгт боржин гнейс .....	40 м
3. Цагаан саарал өнгийн гантиг .....	120 м
4. Кварцитийн үе бүхий (20 м) хар саарал өнгийн, жижиг мөхлөгт биотитот гнейс.....	400м
5. Хар саарал өнгийн биотитот занар .....	220 м
6. Тод хар өнгийн, цул нягт текстуртэй амфиболит .....	6 м
7. Хар саарал өнгийн жижиг мөхлөгт биотитот гнейс .....	50 м
8. Цайвар шаргал өнгийн доломит .....	80 м
9. Хар саарал өнгийн жижиг мөхлөгт биотитот гнейс .....	30 м
10. Цайвар саарал өнгийн цахиржин-гнейсийн (1-2м) үетэй салаавчилал үүсгэсэн, нийцлэг байрлалтай боржин пегматитийн силлээр зүсэгдсэн, цахирын мэшил агуулсан бор саарал өнгийн, судаллаг текстуртэй, биотит-таншит занар .....	500 м
11. Цайвар саарал өнгийн боржин гнейс .....	15 м
12. Хар саарал өнгийн биотит гялтагнуурт занар .....	20м
13. Цахирын (3-4м) мэшил агуулсан, хар саарал өнгийн занар (18-20м) -ын үе бүхий амфиболит.....	250м
14. Бор саарал өнгийн хоёр гялтагнуурт занар .....	60м
15. Хар саарал өнгийн амфиболит .....	20 м
16. Хөх саарлаас бор саарал өнгийн, жижиг мөхлөгт, цул нягт текстуртэй, цахиржин гнейсийн (4-5 м) үе бүхий бор саарал өнгийн, дунд мөхлөгт биотит-гялтгануурт, анарт занар.....	80 м
17. Бор саарал өнгийн, жижиг мөхлөгт, нарийн үеллэг текстуртэй, цахир-жонш-гялтагнуурт гнейс (4-5м) болон цахиржин гнейсийн (1-6м) үеүүдтэй салаавчилал үүсгэсэн бор саарал өнгийн жижиг мөхлөгт биотит-гялтагнуур-таншит занар.....	80 м

Дунд зузаалгийн зүсэлтийн зузаан 2370 м

Энэ зүсэлтийн дээд хэсэг баруун тийш талбайн гадна баруун захад доод-дунд рифейн Бүрдийн голын хурдастай хагарлаар хиллэдэг. Дээрхи зүсэлт нь дээрхи цэгээс баруун хойш Тахилга уул хүртэл алсуур муруйж бүнхэр атирааг үүсгэсэн байдаг.

Дээд зузаалаг (PR1bm3) нь Өшгөгийн нурууны өвөр хэсэгт өвөр Ашнайн уулын орчмоос баруун тийш Таацын гол, Уран хайрхан уулаар дамжин Олон овооны хүрмэн бэгэлцэгийн урд үзүүр хүртэл 3 км өргөнтэй, 12 км урттай тектоникийн блокд илэрдэг. Мөн талбайн гадна баруун захад Тэвшийн Тахилга уулын зүүн талд Хөх дэлийн толгодыг үүсгэн байрлах ба бүнхэр атирааны оройн хэсэгт илрэх дунд зузаалгийн хурдастай хагарлаар хиллэнэ. Дээд зузаалгийн хурдас нь ихэвчлэн гялтагнуурт, хоёр гялтагнуурт занар, амфиболит ховроор гантиг агуулсан, нийцлэг байрлалтай түрүү рифейн плагиоборжингийн силлээр зүсэгдсэн, рего-ниаль метаморфизмын амфиболитын фазад хувирсан чулуулгаас бүрдэнэ.

Дээд зузаалгийн хурдас нь хойт талаараа түрүү рифейн боржингийн массивтай хагарлаар хиллэх ба энэхүү гадаад заагийн хэсэгтээ магнетит, мартит, карбонатаар баяжиж төмрийн

усан ислүүдийн нөлөөгөөр улаан хүрэн өнгөтэй болсон байдаг. Энэ хувирлын бүсийн өргөн нь 150-200м хүрнэ. Гурван толгой уулын өвөр бэлд мөн тектоник-ийн суларсан бүсийн хэсэгт пиритийн 2x2 см хэмжээтэй исэлдсэн шоогоор баяжсан байдаг. Өвөр Ашнайн уулын орчимд доод протерозойн Бөмбөгөрийн бүрдэлийн дунд зузаалгийн хурдастай мөн хагарлаар хиллэх боловч ерөнхийдөө структурын байрлалаараа нийцлэг байрлалтай байх ба литологийн найрлагаараа дээд зузаалагт аажмаар шилждэг. Энд уг зузаалаг нь хөх саарал өнгийн, дунд мөхлөгт, нимгэн хуудсархаг тогтоцтой гялтагнуурт, хоёр гялтгануурт занараас голлон тогтох ба 80-100 м зузаантай тод хар өнгийн амфи-болитийн үе агуулсан байх ба 3-4 м зузаантай боржин пегматит-ийн нийцлэг байрлалтай силлээр зүсэгдсэн байдаг. Мөн зарим хэсэгтээ мигматитжсан байдаг. Өвөр Ашнайн уулын орчимд илэрсэн дээд зузаалгийн зузаан нь ойролцоогоор 1500 м байна.

Доод протерозойн хурдас нь амфиболитын фацад хувирсан ба дараах эрдсүүдийн хам оршлийг үүсгэж байгаа юм. Үүнд: биотит-гялтгануур-анар-цахир-плагиоклаз, анар-эвэр хуурмаг-плагиоклаз-цахир, ховроор микроклин пироксен-цахир-плагиоклазын хам оршлийг үүсгэдэг.

Доод протерозойн Бөмбөгөрийн бүрдлийн хувирмал чулуулгийн химийн шинжилгээний үр дүнг А.А. Маракушевийн диаграмм дээр буулгаж харвал эдгээр нь шүлтлэг эгнээний чулуулагт хамаарах ба цахиурын ислийн найрлагаараа амфиболит болон гнейс, цахиржин гнейсийн талбайд хамарч байна. А.А. Предовскийн аргачлалаар петро-химийн онцлогийг авч үзвэл анхдагч чулуулаг нь вулканоген-тунамал чулуулаг байсан нь харагддаг. Амфиболитууд нь үндсэндээ базитын талбайд буух ба петрохимийн шинжээрээ толейтийн эгнээнд хамаарна. Гялтагнуурт, хоёр гялтагнуурт гнейс, цахир-жин гнейс, занарууд нь А..А. Предовскийн диаграммын фигуратив муруйн дацит, рио-литийн талбайд буудаг.

## 2.9 Ордын нөөц

Судалгааны талбайд тогтоогдсон “Жалга-2” болон “Жалга-3” ордуудын ашигт давхаргууд нь ерөнхийдөө баруунаас зүүн сунаж тогтсон байх бөгөөд хил хязгаар нь хойд болон урд талаараа доод протерозойн Бөмбөгөр формацийн талст занар, гнейсүүд болон дунд-хожуу рифейн габбройд бүхий өндөрдүү эрэг, хадан хясаа, нам толгод гүвээгээр хязгаарлагдана. Харин баруун талын хил нь лизензийн хилээр хиллэх бөгөөд зүүн талууд нь өөрийн хайгуулын талбайд оршино. Ордын нөөцийн дэвсгэр зурагт үзүүлсэн болно.

“Жалга-2” болон “Жалга-3” алтны шороон ордууд нь харьцангуй бага уналтай, жижгэвтэр тэвш маягийн тогтоцтой хөндийг дагаж тогтсон аллювь-пролювь, пролювь гаралтай гол хормойн, хормойн сэвсгэр хурдсанд хуримтлагдсан, тууз маягийн энгийн тогтоцтой юм. Энэ ордуудын алттай давхаргуудад алтны тархац туйлын жигд бус ( $V_c=226\%$ ), давхаргын зузаан мөн жигд бус ( $V_m=74\%$ ) харин давхаргуудын үргэлжлэл нь тогтвортой үзүүлэлттэй юм.

Түүнчлэн ордын геологи-геоморфологийн тогтоцын онцлог, алтны нөөцийн хэмжээ болон дээрх бүх үзүүлэлтээр алтны шороон ордуудыг III бүлгийн ангилалд хамааруулсан юм.

“Үзүүрт” талбайн “Жалга-2” ба “Жалга-3” алтны шороон ордуудад 2021 онд хийж гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнд тулгуурлан тус ордуудын нөөцийг 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар тооцлоо. Энд 200 х 20м -ын хайгуулын торын нягтралтай ба III бүлгийн орд учир бүх хэсэгшилийн нөөцийг боломжтой (С) зэрэгт хамаарууллаа. Нөөцийн тооцооны үр дүнгээс харахад алтны шороон ордуудын нөөцийн харьцаа нь “Жалга-2” ба “Жалга-3” ордууд 90:10 байна.

“Үзүүрт” хайгуулын талбайд алтны шороон ордын шинээр тогтоосон нийт нөөц алтны 2 ордод дараах байдалтай байна.

Үүнд:

1. “Жалга-2” : ”С” зэрэглэлээр-65.63 мян.м<sup>3</sup> элс, 139 мг/м<sup>3</sup> (шлихээр 163 мг/м<sup>3</sup>) дундаж агуулгатай химийн цэвэрээр 9.12 кг (шлихээр 10.7 кг) алт байна.
2. “Жалга-3” : “С” зэрэглэлээр 7.820 мян.м<sup>3</sup> элс, 172мг/м<sup>3</sup> (шлихээр 201мг/м<sup>3</sup>) дундаж агуулгатай химийн цэвэрээр 1.34 кг (шлихээр 1.58кг) алт байна.

Ордуудын хэмжээнд : Нийт: “С” зэрэглэлээр 73.45мян.м<sup>3</sup> элс, химийн цэвэрээр 10.5 кг (шлихээр 12.3кг) алт байна.

#### Ордын үзүүлэлтүүд:

	“Жалга-2”:	“Жалга-3”:
Урт -	1055м	1000м
Өргөн -	96.3 м	32.1
Хучдасын зузаан -	1.63м	1.24м
Давхаргын зузаан -	0.55 м	0.32м
Дундаж агуулга -	163 мг/м <sup>3</sup> (хим.цэврээр-139мг/м <sup>3</sup> )	201мг/м <sup>3</sup> (хим.цэврээр-172мг/м <sup>3</sup> )
Металлын нөөц /С/ -	10,7 кг (хим.цэврээр-9,12кг)	1.57кг (хим.цэврээр-1.34кг)
Нийт металлын нөөц : 12.3кг (химийн цэврээр-10.5кг)		

**Хүснэгт 3. “Үзүүрт” хайгуулын талбай дахь “жалга-2” ба “жалга-3” алтны шороон ордуудын нөөцийн нэгдсэн хүснэгт /СОРЬЦ-852.5/**

## БҮЛЭГ III. ИЛ УУРХАЙ

### Хүснэгт-1 Нөөцийн нэгдсэн хүснэгт

Блоккийн дугаар	Зузаан, м		Дундаж агуулга, мг/м <sup>3</sup>	Блоккийн талбай, мян.м <sup>2</sup>	Эзэлхүүн, мян. м <sup>3</sup>		Металлын нөөц, кг	
	Хөрс	Элс			Хөрс	Элс	Шлих	Цэвэр
1	2	3	4	5	6	7	8	9
<b>“Жалга-2” орд</b>								
1-С	2.3	0.32	316	7.48	17.36	2.39	0.76	0.65
2-С	2.0	0.41	302	18.5	36.81	7.59	2.29	1.95
3-С	1.34	0.64	141	20.33	27.27	13.04	1.84	1.56
4-С	1.3	0.59	104	27.71	36.02	16.23	1.69	1.44
5-С	1.51	0.53	154	22.36	33.73	11.74	1.81	1.54
6-С	1.30	0.79	158	18.53	24.09	14.64	2.32	1.97
<b>Бүгд”С”</b>				<b>114.91</b>	<b>175.28</b>	<b>65.63</b>	<b>10.7</b>	<b>9.12</b>
<b>Дундаж</b>	<b>1.63</b>	<b>0.55</b>	<b>163</b>					
<b>“Жалга-3” орд</b>								
1-С	1.8	0.2	63	1.5	2.7	0.3	0.019	0.016
2-С	1.7	0.2	110	6.97	11.85	1.39	0.153	0.130
3-С	1.5	0.2	101	8.48	12.89	2.04	0.204	0.174
4-С	1.1	0.3	64	6.1	6.91	1.63	0.104	0.089
5-С	0.7	0.4	398	3.86	2.70	1.54	0.614	0.523
6-С	0.6	0.6	521	1.54	0.92	0.92	0.480	0.409
<b>Бүгд”С”</b>				<b>28.44</b>	<b>37.97</b>	<b>7.82</b>	<b>1.58</b>	<b>1.34</b>
<b>Дундаж</b>	<b>1.24</b>	<b>0.32</b>	<b>201</b>					
<b>Нийт талбайн хэмжээнд:</b>								
<b>Бүгд”С”</b>				<b>143.35</b>	<b>213.35</b>	<b>73.45</b>	<b>12.28</b>	<b>10.46</b>
<b>Дундаж</b>	<b>1.43</b>	<b>0.43</b>	<b>167</b>					

### 3.1 Ордын уул-техникийн нөхцөл, ашиглах арга

Ордын уул геологи, уул техникийн нөхцөлүүд нь хайгуулын үе шатны ажлаар дараах байдлаар тодорхойлогдсон байна. Үүнд:

- Ордын нөөц боломжтой зэрэглэлээр (С) нийт 10.46 кг нөөц (химийн цэврээр) байна.
- Алтны шижирмэг бүлэг орд нь нэг давхарга бүхий харьцангуй энгийн тогтоцтой, уул техникийн нөхцлийн хувьд хүндрэлгүй.
- Уул техникийн нөхцөлийн хувьд бул чулуу, хөрсний хөлдөлт зэрэг аливаа хүндрэл байхгүй.
- Хайгуул хийсэн талбайд байрлах ам хөндий урсгал усгүй.
- Ундны болон үйлдвэрлэлийн хэрэгцээний усыг хангах 2 ширхэг гүний худагтай.
- Ордын хучаасын зузаан нь 1.4 м, элсний зузаан 0.4 м, алтны дундаж агуулга нь 0.167 мг/м<sup>3</sup> алтны нөөц шлихээр 12.3 кг, хими цэврээр 10.5 кг байна. Лабораторын шинжилгээгээр алтны сорьцийг 852.5 бол 91.16%-ийн металл авалттай, III бүлгийн орд юм.



- Элсний угаагдах чанар сайн, том чулуулаг багатай тул ашиглахад хялбар юм.

### 3.2 Ил уурхайн хүрээ хязгаар

Ил уурхайн хүрээ хязгаарыг гаргахдаа хөрс хуулалтын хязгаарын коэффициентэд тулгуурлан ордын батлагдсан боломжтой (С) зэргийн нөөцийг олборлохоор уурхайн загварыг хийж гүйцэтгэсэн.

Цаашид эрэл-хайгуулын ажлыг явуулж, ордын нөөцийг нэмэгдүүлэн ашиглах боломжтой гэж үзлээ.

### 3.3 Ил уурхайн ашиглалтын технологи

Ордын уул-техникийн нөхцлөөс хамааруулан ордыг ил уурхайн аргаар, авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглахаар төсөлд тусгалаа.

Бульдозероор дээд давхаргын 0.2 метр хүртэл дундаж зузаантай шимт хөрсийг хуулж уурхайн хил хүрээний гадна түр овоолгод хадгалж үндсэн хөрсийг дотоод овоолгод, хөрсийг ашиглагдсан орон зайд хураахаар тооцсон.

Хамгийн эхэнд нээх блокийн хөрсийг уурхайн хүрээний гадна байршуулж, бусад блокийн хөрсийг ашиглагдсан орон зайд хураахаар тооцсон. Энэ нь нөхөн сэргээлтийн ажлын зардал уурхайн ашиглалтын зардалдаа шингэх сайн талтай шийдэл болж байгаа юм.

Элсийг экскаватор, автосамовалын хослолоор скруббер байрласан талбайд тээвэрлэн хүргэнэ.

#### *Хүснэгт 2. Уурхайн ашиглалтын технологи*

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Автотээвэртэй ашиглалтын технологи	Хөрс хуулалт	Ухаж ачих Тээвэрлэх Овоолох
	Элс олборлолт	Ухаж ачих Тээвэрлэх Овоолох

Ордын ашиглалтын технологийн схем, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтэд тулгуурлан ил уурхайн үндсэн параметруудийг сонгосон. Үүнд:

Доголын өндөр: Ордын хэмжээнд хөрсний хэмжээ маш бага, тул доголын өндрийг 1.5 м байхаар тооцов.

Доголын налуугийн өнцөг: Ил уурхайн ажлын доголын өнцгийг хөрс хуулалтын гүн бага, дунд зэргийн чулуулагт ажлын доголын өнцөг нь 60-70° хооронд байдаг, уг үндэслэлээр 65° байхаар тооцлоо.

Уурхайн замын өргөн: Уурхайн замын өргөнийг тухайн замаар явах тоног төхөөрөмжийн овор хэмжээнээс хамааруулан 10 м байхаар тооцсон.

### Хүснэгт 3. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд


№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Ил уурхайн ажлын доголын өндөр	м	02-2.3
2	Аюулгүйн бермийн өргөн	м	0.5
3	Доголын налуугийн өнцөг	градус	65
4	Траншейн замын өргөн	м	10
5	Траншейн дагуу налуу	‰	90

### 3.4 Ил уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Ашиглалтын үеийн бохирдлыг 3 ангилсан ба уулын цулаас салгасан ашигт малтмалын хаягдал буюу ачих, буулгах, тээвэрлэх, нөөцлөх үед 1%-ийн хаягдалтай байхаар тооцсон.

Ашиглалтын үеийн бохирдол нь:

1. Улны бохирдол
2. Таазны бохирдол зэргээс бүрдэнэ.
3. Хажуугийн



Зураг-2 Ашиглалтын үеийн бохирдол



### 3.5 Ил уурхайн хүчин чадал, ашиглалтын хугацаа, ажлын горим

#### *Төслийн хүчин чадал, орд ашиглалтын хугацаа*

Уурхайн хүчин чадал, орд ашиглах хугацааг Захиалагч компанийн өгсөн техникийн даалгаварын дагуу ордыг 1 жилийн хугацаанд ашиглах бөгөөд 88.7 мян.м<sup>3</sup> элс олборлоно.

#### *Уурхайн ажлын горим*

Уурхайн ажил улирлын чанартай буюу дулааны улиралд 06-р сарын 03-ний өдрөөс 10-р сарын 31-ний өдөр хүртэл 5 сарын хугацаа буюу 150 хоног ажиллах боломжтой. Уурхайн ажлын горимыг жилд амрах баяр ёслолын хоног, цаг агаарын хүндрэлийн хоног, мөн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний хоногуудыг тус тус оруулан тооцлоо.

#### *Хүснэгт 4. Уурхайн ажлын горим*

№	Үзүүлэлт	Утга
1	Жилийн календарийн хоног	153
2	Жилд амрах хоног	3
	Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ	7
	Болзошгүй цаг агаарын хүндрэл	7
3	Жилд ажиллах хоног	138
4	Хоногт ажиллах ээлжийн тоо	2
5	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	12

#### *Ил уурхайн төлөвлөлт*

Ил уурхайн төлөвлөлтийг ил уурхайн хүрээн дэх нөөцөд тулгуурлан хийлээ. Олборлолтын төлөвлөгөөг боловсруулахдаа блокуудыг нэг талаас нь хөөх маягаар авто тээвэртэй, гадаад, дотоод овоолго бүхий ашиглалтын системээр уулын ажлыг явуулахаар тооцлоо.

**Ашиглалтын технологи.** Үзүүрт нэртэй талбайн “Жалга-2”, “Жалга-3” алтны шороон ордын уул техникийн нөхцөл үзүүлэлтээс харахад тус орд нь хөрсний хурдас нь том бул чулуу, цэвдэгшил байхгүй, уул техникийн нөхцөл сайн, гидрогеологийн нөхцөл энгийн тогтоцтой, хамгийн ихдээ 3.0 метр хүртэлх ухаш үүснэ. Ашигт давхарга нь босоо байрлалаараа улирлын хөлдөлтөнд бараг ордоггүй учир уул-геологийн хувьд олборлолтын явцад онцын хүндрэл үүсэхгүй.

**Уурхайн нээлт:** Ордыг гадаад туслах траншейгаар “Жалга-2” хэсгийн С-6 блокоос эхлэн нээж С-5, С-4, С-3 дарааллаар олборлоно. Гадаад туслах траншей замын өргөн 10 м, замын налуу 90 промилль байна. Уурхайн нээлтийн ажлаар гарах хөрсийг С-6 блокын баруун хэсэгт байрлах дунджаар 1.0 м гүнтэй, 1.03 га бүхий гар аргаар алт олборлогчдын үүсгэсэн ухаш хэсэгт дотоод овоолгод байршуулах ба шимт хөрсийг экскаватор, автосамосвалын тусламжтай зөөж уурхайн хүрээний гадна 30-40 м-ийн зайд овоолно.



**Үржил шимт хөрс хуулалт:** Ордын ашиглалтын явцад уулын ажил явагдахаар төлөвлөгдсөн талбайн өнгөн хөрсийг Монгол улсад дагаж мөрддөг шаардлага стандартын дагуу 0.2 метр зузаантайгаар экскаватор, автосамосвалын тусламжтай уурхайн хүрээний гадна 30-40 м-ийн зайд зөөн овоолж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглана. Шимт хөрсний овоолгын өндөр нь 2.0 м байх бөгөөд хажуугийн тогтворжилтын өнцөг нь 35 градус байна. Шимт хөрсийг хуурай сэрүүний улиралд хуулах нь тохиромжтой бөгөөд овоолгыг аль болох нөмөр газар хийх ба тийм боломжгүй тохиолдолд шимт хөрсний овоолгыг сууж дагтарштал нь тусгай зориулалтын торон хучилт хийж салхи шуурганд хийсэхээс сэргийлэх болон ургамалжуулж болно. Шимт хөрсийг уурхайн үндсэн хөрс хуулалтын ажлаас өмнө хуулж овоолсон байна.

**Хөрс хуулалтын ажил:** Ил уурхайг нээх буюу эхлэх үед хөрсний чулуулгийг экскаватор - автосамосвалын хослолоор олборлолтын талбайн гадна гадаад овоолго хийнэ. Ийнхүү хөрс хуулалт болон элс олборлолтыг явуулж тухайн хэсэгт тодорхой хоосон орон зай гаргаж, дараагийн олборлолтын блокийг гарсан орон зайд экскаватор-автосамосвалын хослолоор зөөвөрлөн дотоод овоолгод байршуулах замаар хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэнэ. Хөрс хуулалтын ажлын доголын өндөр 5 м байна. Хөрсний гадаад овоолгын доголын өндөр 2-10 м, доголын налуугийн өнцөг 35 градус байна.

**Элс олборлолтын ажил:** Элс олборлолтын догол, мөргөцгийн өндөр нь мөн элсний давхаргын зузаанаас шалтгаалж уурхайн дунджаар 1.1 м байна. Олборлолтын ажлыг экскаватор, автосамосвалын хослолоор ухаж ачин тээвэрлэж баяжуулах төхөөрөмжийн дэргэд байрлах элсний түр овоолгод овоолно.

Үзүүрт талбайн “Жалга-2”, “Жалга-3” алтны ордыг ил уурхайн аргаар ашиглах уурхайн төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүллээ.

**Хүснэгт 5. “Жалга-2”, “Жалга-3” алтны шороон ордыг ашиглах төлөвлөгөө**

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	“Жалга-2”, “Жалга-3”
1	Хөрс хуулалт	мян.м <sup>3</sup>	178.19
2	Шимт хөрс хуулалт	мян.м <sup>3</sup>	33.61
3	Элс олборлолт	мян.м <sup>3</sup>	88.7
4	Уулын цул	мян.м <sup>3</sup>	300.5
5	Хөрс хуулалтын коэффициент	м <sup>3</sup> /м <sup>3</sup>	2.4





### 3.7 Уурхайн процессууд, үндсэн тоног төхөөрөмж


Ил уурхайн тоног төхөөрөмжүүдийг төсөл хэрэгжүүлэгчийн ажлын даалгаварт тусгасны дагуу одоо ашиглаж байгаа техникүүдийг үргэлжлүүлэн ашиглахаар тусгаж тооцсон болно.

Ил уурхайн хөрс хуулалтын ажилд Liebherr R-924 маркын экскаватор 1 ш, элс олборлолтод Liebherr R-924 маркын экскаватор 1 ш, хөрс тээвэрлэлтийн ажилд North benz 2527k маркын 20т даацтай автосамосвал 2 ш, элс тээвэрт North benz 2527k маркын 20т даацтай автосамосвал 2 ш тус тус ашиглана.

Ул тааз цэвэрлэгээ, өрөмдлөгийн ажл явуулах талбай тэгшлэх, хөрсний гадаад, дотоод овоолгод Shantui SD23 маркийн бульдозер 1ш, скрубер тэжээлээр хангах болон туслах XG955H маркийн 3 м<sup>3</sup> утгуурын багтаамжтай утгуурт ачигч 2 ш тус тус ашиглана.

#### *Хүснэгт 6. Ил уурхайн үндсэн болон туслах процессын тоног төхөөрөмжүүд*

№	Тоног төхөөрөмжийн нэр, марк	Үзүүлэлт	Ашиглалтын жил	Өмчлөлийн хэлбэр
1	Экскаватор – Liebherr R-924	1.25 м.куб	2	Өөрийн
2	Автосамосвал – North benz 2527k	20 тн	4	
3	Бульдозер – Shantui SD23	6.5 м.куб	1	
4	Утгуурт ачигч – XGMA-XG955H	3.0 м.куб	1	
5	Усны машин – Майти	5 тн	1	
6	Түлшний машин – Майти	5 тн	1	



Зураг-3 Ил уурхайн процессын схем



### Хүснэгт 7. Экскаваторын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмж их нэгж	Хөрс, элс
			Libherr R-924
1	Утгуурын багтаамж	м <sup>3</sup>	1.25
2	Утгалтын түвшин дэх хамгийн их радиус	м	9.5
3	Утгалтын хамгийн их гүн	м	6.95
4	Ачилт хийх хамгийн их радиус	м	9.8
5	Ачилтийн хамгийн их өндөр	м	6.9
6	Арын эргэлтийн радиус	м	3.3
7	Хөдөлгүүрийн чадал	кВт	158
8	Явах хурд	км/цаг	2.6
9	Масс	тн	29.3
10	Явах эд ангийн овор хэмжээ		
10.1	Урт	м	3.6
10.2	Өргөн	м	2.97
10.3	Өндөр	м	30



### Хүснэгт 8. North benz автосамосвалын техникийн үзүүлэлт

Техникийн үзүүлэлтүүд	North Benz 2527K
Даац	20
Машины өөрийн жин	15.6
Хөдөлгүүрийн төрөл	WP10.270
Тэвшний багтаамж	17 м3
Хөдөлгүүрийн дээд чадал	270 Ps/rpm
Хөдөлгүүрийн дээд эргэлт	1100 N.m
Дугуйн тэнхлэг хоорондын зай	3800+1450
Дугуйн гадаргуу	12.00-20/11.00-20
Дээд хурд	≥85
Хөтлөгчийн хэлбэр	6X4
Тэвшний хэмжээ	5200*2300*1500



### Хүснэгт 9. Бульдозерын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	SD23	
1	Хусуурын хамах чадвар	м3	2.8	
2	Хусуурын өргөн	м	2.6	
3	Хусуурын өндөр	м	1.1	
4	Хусуурын хөрсөнд шигдэх гүн	м	0.35	
5	Хөдөлгүүрийн чадал	кВт	187	
7	Явах хурд:	түрэх үед	км/цаг	4.2
		ухрах үед	км/цаг	6.5
8	Овор хэмжээ:	урт	м	4.8
		өргөн	м	2.3
		өндөр	м	2.4
9	Түлшний сав	л	305	
10	Жин	тн	24	
11	Дундаж түлш зарцуулалт, мот/цаг	л	22	



*Хүснэгт 10. Эскаваторын бүтээлийн тооцоо*

№		Үзүүлэлт	Х.н	Liebherr R-924	Liebherr R-924
1		Ажиллах эскаваторын төрөл		Хөрс	элс
2		Утгуурын багтаамж	м3	1,25	1,25
3	Hmax	Ажлын доголлын хамгийн их өндөр	м	1,50	1,50
4	Aop	Эскаваторын орлын өргөн	м	14,98	14,98
5	Ryt	Утгалтын түвшин дэх радиус	м	9,36	9,36
6	пор	Эскаваторын орлын тоо	тоо	1,00	1,00
7	tэм	Циклийн хугацаа	сек	28,00	28,00
8	tэр	Эргэх хугацаа	сек	6,00	6,00
9	ty	Утгах хугацаа	сек	12,00	12,00
10	tac	Асгах хугацаа	сек	4,00	4,00
11	Куд	Утгуур дүүргэлт	-	0,90	0,85
12	Кэт	Эскаваторын төрлийг тооцох итгэлцүүр	-	0,90	0,90
13		Техникийн бэлэн байдлын итгэлцүүр	-	0,90	0,90
14	Кус	Утгуур дахь чулуулгийн сийрэгжилт итгэлцүүр	-	1,20	1,20
15	Км	Мөргөцгийн нөхцөл тооцох итгэлцүүр	-	0,95	0,90
16	Коп	Операторын ур чадварын итгэлцүүр	-	0,95	0,90
17	Qтех	Эскаваторын техникийн бүтээл I цаг	м3/цаг	88,11	74,69
18	Кэц	Ээлжийн цаг ашиглалтын итгэлцүүр	-	0,85	0,85
19	Тэ	Ээлжинд ажиллах хугацаа	цаг	12,00	12,00
20	Ктх	Эскаваторыг тээврээр хангах нөхцөл тооцох итгэлцүүр	-	0,90	0,90
21	Кма	Мөргөцөг дахь ахилт шилжилтийг тооцох итгэлцүүр	-	0,93	0,93
22	Qээ	Ээлжийн бүтээл	м3/ээлж	752,27	637,66
23	пэ	Ээлжийн тоо		2,00	2,00
24	Qэх	Хоногийн бүтээл	м3/хоног	1 504,54	1 275,32
		Сарын бүтээл	м3/сар	45 136,19	38 259,48
25		Жилд ажиллах хоног /Техникийн/	хоног	145	126
26	Qэж	Жилийн бүтээл /Техникийн/	м3/жил	218 158,23	160 689,82
27		Эскаваторын жилд ажиллах цаг	мото.ц	2 475,85	2 151,42
28		Нэг шанаганд утгагдах чулуулгийн хэмжээ	м3	1,35	1,28
29	Va	Автосамосвалын тэвшний багтаамж	м3	15,60	15,60
30	n	Утгалтын тоо	ш	12,48	12,48
31	tac	Нэг автосамосвалыг ачих хугацаа	мин	6,07	6,07

Баянхонгор, Өвөрхангай аймгийн Өлзийт, Нарийнтээл сумдын нутагт орших Үзүүрт талбайн “Жалга-2”, “Жалга-3” алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл





**Хүснэгт 11. Автосамосвалын бүтээлийн тооцоо**

№	Үзүүлэлт	Х.н	Хөрс	Элс
1	Автосамосвалын загвар		North benz 2527k	North benz 2527k
2	Тээврийн зай, нэг талдаа	м	550,00	1 860,00
3	Ачаалах хугацаа	сек	364,00	364,00
4	Автосамосвалын хөдөлгөөний хугацаа	сек	145,20	390,60
5	Ачаатай явах хугацаа	сек	79,20	223,20
6	Хоосон явах хугацаа	сек	66,00	167,40
7	Асгах хугацаа	сек	20,00	20,00
8	Автосамосвалын рейсийн хугацаа	сек	529,20	774,60
9	Экскавацлалтын итгэлцүүр		0,80	0,80
10	Тэвшний багтаамж ашиглалтын итгэлцүүр		0,85	0,85
11	Утгалтын тоо, тэвшний багтаамж	ш	8	6
12	Автосамосвалын бэлэн байдлыг тооцох итгэлцүүр		0,80	0,80
13	Операторын ур чадварын итгэлцүүр		0,95	0,95
14	Замын нөхцөл тооцсон итгэлцүүр		0,85	0,90
15	Чулуулгийн сийрэгжилт тооцох коэффициент		1,20	1,20
16	Цагийн бүтээл	м <sup>3</sup>	79,69	31,34
17	Автосамосвалын ээлжийн бүтээл	м <sup>3</sup>	796,88	313,44
18	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12,00	12,00
19	Цаг ашиглалтын итгэлцүүр		0,83	0,83
20	Ээлжийн тоо	ээлж	2,00	2,00
21	Хоногийн бүтээл	м <sup>3</sup>	1 593,76	626,89
22	Жилд ажиллах хоног	хоног	145,00	126,00
23	Жилийн бүтээл	м <sup>3</sup>	231 095,2	78 987,54

**Хүснэгт 12. Бульдозерын техникийн бүтээлийн тооцоо**

д/д	Үзүүлэлт	Хэм.нэгж	SD23
1	Цагийн турш овоолгод ачаа буулгах автосамосвалын тоо	ш	13
2	Нэг цагт хөрс хуулалт, хаягдлын овоолгын хэмжээ /max/	м <sup>3</sup> /ц	127
3	Хөрс хуулалтын хэмжээ	м <sup>3</sup> /ээлж	1,270
4	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12.0
5	Экскаватор, автосамосвалын жилийн ажлын хоног	хоног	192
6	Экскаватор, автосамосвалын хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	2.0
7	Уурхайн жигд бусыг тооцох итгэлцүүр	1.25-1.5	1.25
8	Овоолго дээр нэг зэрэг буулгалт хийх автосамосвалын тоо	ш	2.0
9	Овоолго дээр автосамосвал буулгалт сэлгээ хийх хугацаа	цаг	0.02
10	Ачаагаа саадгүй буулгах овоолгын хэсгийн урт	м	40
11	Овоолго дээрх буулгалт хийх хэсгийн тоо	ш	2.0
12	Овоолго дээр тэгшлэлт хийх хэсгийн тоо	ш	1.0
13	Овоолго дээрх нөөц хэсгийн тоо	ш	1.0
14	Овоолго дээрх хэсгүүдийн нийт тоо	м	4.0
15	Овоолгын фронтын урт	м	120.0
16	Овоолгын тогтвортой өнцөг	град	32.0
17	Овоолгын хажуугийн өнцөг	град	35.0
18	Асгацын өнцөг	град	32.0
19	Асгацын хөндлөн огтлолын талбай	м <sup>2</sup>	9.19
20	Автосамосвалын тэвшний өргөн	м	3.1



21	Үлдэц асгацын хөндлөн огтлолын талбай	м <sup>2</sup>	2.4
22	Овоолгын өндөр	м	15.0
23	Овоолгын ирмэгээс зөвшөөрөгдөх зай	м	2.58
24	Автосамосвалаас буух чулуулгийн эзлэхүүн	м <sup>3</sup>	32.4
25	Овоолго дээр асгалтын дараа үлдцийг тооцох итгэлцүүр	%	26.16
26	Түрэлт хийх тоо		1
27	Түрэх призмийн хөндлөн огтлол	м <sup>2</sup>	1.86
28	Хусуурын өндөр	м	1.14
29	Түрэгдэх чулуулгийн призмийн налууугийн өнцөг	град	35.0
30	Хусуурын урт	м	3.38
31	Сэлгээг тооцох итгэлцүүр	0.8-0.9	0.8
32	Операторын ур чадварын итгэлцүүр	-	0.95
33	Техникийн бэлэн байдлыг тооцсон итгэлцүүр	-	0.95
34	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.83
35	Овоолго дээр бульдозероор гүйцэтгэх ажлын хэмжээ	м <sup>3</sup> /цаг	424.4
36	Овоолго дээр гүйцэтгэх ажлын ээлжийн хэмжээ	м <sup>3</sup> /ээлж	4,244.0
39	Шаардлагатай бульдозерын тоо /тооцооны/	ш	0.3
40	Шаардлагатай бульдозерын тоо /бодит/	ш	1.0

### 3.8 Туслах тоног төхөөрөмж

Уурхайн олборлолтын болон туслах ажилд хэрэглэх зорилгоор 3м<sup>3</sup> утгуурын багтаамжтай Хятад улсад үйлдвэрлэгдсэн ХGMA-XG955H төрлийн утгуурт ачигч ажиллана.

#### Хүснэгт 13. утгуурт ачигчийн техникийн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
Шанаганы багтаамж	м <sup>3</sup>	3.0
Өөрийн жин	тн	15.8
Зүтгэх хүч	кН	150
Номинал ашигт ачаалал /кг/	кг	5000
Шилжих хүч /кН-кило-Ньютон/	кН	155
Явах хурд /км/цаг/ Урагш	км/цаг	11.5-36.0
Явах хурд /км/цаг/ Ухрах	км/цаг	16
Хөдөлгүүр	-	WEICHAI
Хүчин чадал /kw/эргэлт/минут/	эрг/мин	162/2200
/kw/эргэлт/минут/	эрг/мин	850/1400
Асаах хүчдэл /В/	В	24
Дамжуулалт	-	
Араа	-	2F/1R
Дугуй	-	23.5-25 L-3 16PR
Шатахууны банк /л/	л	360



#### Хүснэгт 14. ХGMA-XG955H утгуурт ачигчийн бүтээлийн тооцоо

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
----------	-------------	------



Ухаж ачих мөчлөгийн хугацаа (тум)	сек	53
Чулуулгийг утгах хугацаа (тут)	сек	9
Ачаатай үеийн хөдөлгөөн (тах)	сек	17
Хоосон үеийн хөдөлгөөн (тхх)	сек	17
Сэлгээ хийж шилжих нэг талын зай (Lш)	м	25
Утгуурт ачигчийн ажиллах хугацаа (цаг)	ээлж	12
Мөргөцөг орчимд шилжилт хөдөлгөөн хийх хурд (Vх)	м/сек	1.5
Цагт хийх рейсийн тоо (nр)	удаа	69
Утгуур дүүргэлтийн коеф (Куд)	-	1.2
Утгуур дахь сийрэгжилтийн коеф (Кс)	-	1.2
Хаягдлыг тооцох коэффициент	-	0.98
Операторын ур чадварыг тооцох коэффициент (Куч)	-	0.95
Утгуурт ачигчийн цаг ашиглалтын коеф (Куа)	-	0.83
Утгуурт ачигчийн төрлийг тооцох коеф (Кту)	-	1.05
Техникийн бэлэн байдлыг тооцсон итгэлцүүр	-	0.95
Утгуурт ачигчийн цагийн бүтээл (Quц)	м <sup>3</sup> /цаг	191.65
Утгуурт ачигчийн ээлжийн бүтээл (Quэ)	м <sup>3</sup> /ээлж	1,908.0
Утгуурт ачигчийн хоногийн бүтээл (Quх)	м <sup>3</sup> /хоног	3,817.0
Жилд ажиллах хоног (nах)	хоног	123
Утгуурт ачигчийн жилийн бүтээл (Quх)	м <sup>3</sup> /жил	469 491,0



## БҮЛЭГ IV. БАЯЖУУЛАХ ХЭСЭГ

2021 онд “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын лабораторид “Үзүүрт”-ийн алтны шороон ордын 1200 кг алт агуулагч элсний сорьцод технологийн туршилт хийж тайланг боловсруулжээ.

Технологийн туршилтын тайлангийн ажлын хүрээнд:

1. Эрдсийн найрлагын нарийвчилсан судалгаа, дүгнэлт
2. Гравитацийн аргаар баяжигдах чанарын туршилт шинжилгээ дүгнэлт хийсэн.

### 4.1. Ордын элсний найрлага, минерлогийн шинжилгээ

Баянхонгор, Өвөрхангай аймгийн Өлзийт, Нарийнтээл сумын нутагт орших хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайн “Үзүүрт”-ийн алтны шороон ордын дээжинд нарийвчилсан эрэл-хайгуулын ажил хийж буй “Импери Майнинг” ХХК нь Геологийн Төв Лабораторит технологийн туршилт хийлгүүлэхээр дээж ирүүлсэн болно. Технологийн туршилтанд ирсэн тус дээжийг -80, +60,+40, +20,+10, +5, +2, -2 мм-ийн ангиллуудад хуваан шигшиж ба төрөл бүрээс дээж авч өнгөлсөн тунгалаг шлиф бэлтгүүлэн минераграфи, петрографийн шинжилгээ хийж гүйцэтгэсэн болно.

“Импери Майнинг” ХХК-ийн “Үзүүрт”-ийн алтны шороон ордын технологийн дээжийн бодисын найрлагын судалгаанаас дор дурдсан дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Тухайн ордын дээж нь хувирсан жигд бус мөхлөгт диорит түүний хувирлын үр дүнд үүссэн эрдэслэг бүрэлдэхүүнээр ялгаатай гнейс, сул гнейсжсэн габбродиорит, болон базальт зэрэг чулуулгаас тогтжээ.

- Хувирсан жигд бус мөхлөгт диорит нь призмлэг мөхлөгт, лепидонематогранобластлаг структур, параллель текстурыг үүсгэсэн плагиоклаз, амфибол, биотитоос тогтжээ.
- Гнейсжсэн жигд бус мөхлөгт кварцат диорит нь гипидиоморфлог, лепидогранобластлаг структур, сул гнейслэг текстуртай, плагиоклаз, кварц, гялтгануураас тогтжээ.
- Гнейс нь гялтгануур-гранат-кварц-плагиоклазат болон плагиоклаз-амфиболт найрлагатай бөгөөд лепидонематогранобластлаг, гранонематобластлаг структур, гнейслэг текстуртай болно.
- Сул гнейсжсэн габбродиорит нь габброилог структур, гнейс маягийн текстурыг үүсгэсэн зонхилох хэмжээний плагиоклаз, амфибол, бага зэргийн пироксеноос тогтжээ.
- Базальт нь оливиний порфирууд болон интерсерталь структур, цул текстуртай үндсэн хэсгээс тогтжээ.





2. Минералогийн шинжилгээгээр 497.097 мг жин бүхий тод шар болон улаавтар шар өнгийн хумхиа, зөв бус, хавтгай, гонзгой, бөөрөнхий хэлбэртэй, хагас мөлгөржсөн нарийн тоосонцороос том ширхэгтэйд тооцогдох 0.03x0.03 мм-ээс-1.14-1.83 мм хэмжээтэй алт гарсан болно. Алтны зариммөхлөг нь төмрийн усан ислээр бага зэрэг бүрхэгджээ. Бүх ангилалд алт агуулагдаж байгаа бөгөөд нийт алтны 20.05% нь -2+1 мм-ийн ангилалд, 51.95% нь -1+0.5 мм-ийн ангилалд, 26.34% нь -0.5+0.25 мм-ийн ангилалд, 1.47% нь -0.25+0.125 мм-ийн ангилалд, 0.17% нь -0.125+0.63 мм-ийн ангилалд, -0.063 мм-ийн ангилалд 0.016% тус тус ноогдож байна. Үүнээс үзвэл бүх алтны 99.81% нь -2+0.125 мм-ийн ангилалд агуулагдаж байна.


### **Технологийн туршилт шинжилгээ**

Баянхонгор, Өвөрхангай аймгийн Өлзийт, Нарийнтээл сумын нутагт орших “Үзүүрт”-ийн алтны шороон ордоос захиалагчийн авч ирүүлсэн 1200 кг жинтэй дээжинд лабораторийн технологи туршилтыг хийж гүйцэтгэсэн.

Туршилтыг шлюз, сэгсрэх ширээ болон гар тэвш (лотки) ашиглан гравитацийн аргаар гүйцэтгэсэн болно.

#### **4.1.1 Сорьц бэлтгэл**

Дээжийг туршилтанд бэлтгэсэн нь: Дээжийг тусгайлан цэвэрлэж бэлдсэн талбайд асгаж, физик механикийн шинжилгээнд зориулан сорьц авахуулав. Дараа нь дээжээ 80 мм, 60 мм, 40 мм, 20 мм-ийн тороор шигшиж, -20 мм-ийн ангилалыг технологи туршилтанд ашигласан. Технологи туршилтаас гарсан бүтээгдэхүүн тус бүрийг 10 мм, 5мм, 2 мм-ийн тороор шигшин, жинг нь авч, гарцыг тодорхойлсны дараа ангилал тус бүрээс петрографийн шинжилгээнд дээж сонгуулсан. -2 мм-ийн ангиллын дээжээс 1 кг дээж зохих аргачлалын дагуу авч ширхэглэлийн бүтцийг тогтоох зорилгоор 1 мм, 0.5 мм, 0.25 мм, 0.125 мм, 0.075 мм-ийн шигшүүрүүдийг хэрэглэн дээжийг нойтон орчинд шигшив.



Зураг-5. Дээжийг туршилтанд бэлтгэсэн бүдүүвч

#### 4.1.2 Элсний сорьцын угаагдах чанар

Алтны шороон ордын элсний угаагдах шинж чанарыг тодорхойлохдоо ОХУ-ын ЦНИГРИ-д боловсруулсан аргачлалыг ашиглав. Энэ аргачлал нь шороон ордын алтны дээжийг боловсруулахад хамгийн зохимжтойд тооцогддог. Уг аргачлалаар элсний угаагдах шинж чанарын зэргийг дараах томъёогоор тодорхойлдог.

$$E = \frac{K \cdot \gamma_1}{\gamma_2 \cdot W}$$

Үүнд: E-элсний угаагдах шинж чанарын итгэлцүүр

K- дээжийн - 0.125 мм ангилал дахь шаварлаг хэсгийн уян налархайн тоо;

$\gamma_1$  - дээжийн 125 мм-ээс бага хэсгийн гарц, %;

$\gamma_2$  - дээжийн 10 мм-ээс том ширхэгтэй хэсгийн гарц, %;

W- анхдагч дээжийн чийглэг, %.

Тодорхойлогдсон итгэлцүүрийн үр дүнгээс хамаарч элсний угаагдах чанар дараах ангиллуудын аль нэгт хамаарагдана.

Үүнд: E<1 хялбар угаагдах;

E=1-1.5 дунд зэрэг угаагдах;

E>1.5 хэцүү угаагдах.



**Хүснэгт 15. Элсний сорьцын угаагдах шинж чанарын үзүүлэлтүүд**

Дээжийн физик-механикийн шинж чанарын үзүүлэлтүүд	Илэрхийллийн тоон утга
К -дээжийн 0.125 мм-ээс бага ширхэгтэй хэсгийн уян налархайн тоо	0
у <sub>1</sub> - дээжийн 0.125мм-ээс бага хэсгийн гарц, %	1.57
у <sub>2</sub> - дээжийн 10 мм-ээс том хэсгийн гарц, %	34.7
W - анхдагч элсний чийглэг, %	2.55
E- элсний угаагдах чанарын итгэлцүүр	0

Тодорхойлогдсон итгэлцүүрийн тоон утга 0 буюу E<1 гарч байгаа учир элс нь угаагдах чанарын үзүүлэлтээр сайн угаагдах ангилалд хамаарагдаж байна.

**4.1.3 Шигшүүрийн шинжилгээний үр дүн**

**Хүснэгт 16. Шигшүүрийн шинжилгээний үр дүн**

№	Ширхэгийн ангилал, мм	Дээжний гарц, %	Гарц, %		Алтны жин, мг	Алтны тархац, %
			Дээрээс	Доороос		
1	+80	0.00	0.00	100.00		
2	-80+60	1.33	1.33	98.68		
3	-60+40	3.17	4.50	95.50		
4	-40+20	12.08	16.58	83.42		
5	-20+10	12.33	28.92	71.08		
6	-10+5	6.13	35.05	64.95		
7	-5+2	11.11	46.16	53.84		
8	-2+1	7.16	53.32	46.68	99.05	20.05
9	-1+0.5	17.03	70.34	29.66	256.67	51.95
10	-0.5+0.25	18.98	89.2	10.68	130.16	26.34
11	-0.25+0.125	8.78	98.10	1.90	7.28	1.47
12	-0.125+0.075	1.57	99.67	0.33	0.86	0.17
13	-0.075	0.33	100.00	0.00	0.08	0.02
	<b>Нийт</b>	100.00			494.10	100.0
	<b>Алтны дундаж агуулга</b>			0.41 мг/т		
				707 мг/м <sup>3</sup>		

“Үзүүрт”-ийн шороон ордын дээжинд хийсэн шигшүүрийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд 1200 кг дээжнээс нийт 494.10 мг алт гарсан бөгөөд алтны дундаж агуулгыг тооцож үзэхэд 0.41 г/т буюу 0.707 г/м<sup>3</sup> гарсан болно.

**4.1.4 Баяжуулах технологийн туршилт**

-20 мм-ийн ангиллын дээжийг шлюзээр баяжуулсан. Харин +20 мм-ийн ангилалд бүхэл алт байгаа эсэхийг хянаж, усаар угааж шламыг нь -20 мм-ийн ангилалд нийлүүлэн лабораторийн нөхцөлд зориулсан гар хийцийн шлюз ашиглан туршилтын ажлыг гүйцэтгэсэн болно. Шлюзны баяжуулалтаар баяжмал ба хаягдал гэсэн 2 төрлийн бүтээгдэхүүн гарган авсан. Шлюзны баяжмалыг сэгсрэх ширээгээр гүйцээн баяжуулж, гарсан баяжмалыг минералогийн шинжилгээнд өгч алтыг ялгуулан,



шигшүүрийн шинжилгээ хийлгэн, ангилал тус бүрийн жинг авсан болно. Туршилтын бүдүүвчийг зураг 2-д, шлюз болон сэгсрэх ширээгээр баяжуулсан туршилтын үр дүнг хүснэгт 4-д үзүүлэв.



Зураг -6. Дээжийг шлюз ба сэгсрэх ширээгээр баяжуулсан туршилтын бүдүүвч

**Хүснэгт 17. Дээжийг шлюзээр баяжуулсан технологи туршилтын бүтээгдэхүүний нэгдсэн дүн**

№	Бүтээгдэхүүний нэр	Гарц, %	Алтны агуулга, г/м3	Металл авалт, %
1	Анхдагч дээж угаалт, шигшилт	100.00	-	-
2	20мм-ээс том ширхэгтэй хэсэг	16.58	-	-
3	20мм-ээс бага ширхэгтэй хэсэг	83.42	0.55	100.00
4	Бүгд	100.00	0.41	100.00
<b>Шлюз</b>				
1	Шлюзны баяжмал	0.27	143.78	86.16
2	Шлюзны хаягдал	83.15	0.08	13.84
3	Бүгд	83.42	0.55	100
<b>Шигшүүр</b>				
1	+2 мм	0.16	0.00	0.00
2	-2 мм	0.11	0.00	0.00
3	Бүгд	0.27	143.78	86.16
<b>Сэгсрэх ширээ</b>				
1	Ширээний баяжмал	0.02	1882.46	84.58
2	Ширээний хаягдал	0.25	8.07	1.58
	Бүгд	0.11	0.00	86.16

Хүснэгт 23-д үзүүлсэн үр дүнгээс харахад тухайн алт агуулсан элсийг шлюз болон сэгсрэх ширээ ашиглан баяжуулахад 0.02%- ийн гарцтай, 84.58%-ийн металл авалттай баяжмал гарган авсан болно.





#### 4.7. Угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмжүүд

“Империо Майнинг” ХХК- нь элс угаан баяжуулах цехийн скруббер, шлюз, сэгсрэх ширээ, насос зэрэг төхөөрөмжүүдийг шинээр худалдаж авна

##### *Скруббер сонголтын тооцоо*

Угаах төхөөрөмжийн бункерыг экскаватораар тэжээн өгч угаасны дараа +20 мм ангилалын бүтээгдэхүүн нь стакераар галийн овоолгод хураагдан овоолго үүсгэнэ. Харин -20 мм ангиллын бүтээгдэхүүн шлюзэнд орж б=аяжигдна. Ийнхүү угаах үйл ажиллагаа тасралтгүй 20 цаг явагдсаны дараа шлюзийн баяжмалыг (ойролцоогоор 1-2 м<sup>3</sup>) авч гүйцээн баяжуулах цехэд ахин баяжуулж цэвэр металлыг гарган авна.

*Ашиглагдах Скрубберийн тоог олбол:*

$$n = \frac{Q_T}{Q} = \frac{40}{40} = 1 \approx 1$$

#### *Хүснэгт 18. Скрубберын техникийн үзүүлэлт*

Д/д	Скрубберийн марк	40
1	Хучин чадал, м3/цаг	40
2	Скрубберийн урт, м	4
3	Бункерийн урт, м	2
4	Чарганы урт, м	7
5	Шлюзийн өргөн, м	2,1
6	Шлюзтэй нийт өргөн, м	5,6
7	Хөдөлгүүрийн чадал, кВт	22
8	Жин, кг	-
9	Ашиглагдах тоо, ширхэг	1

##### *Сэгсрэх ширээ*

Угаан баяжуулах цех нь нэг ширхэг баяжуулах ширээтэй байх ба шлюзийн баяжмалыг баяжуулж шлихийн алт гарган авах үүрэгтэй байна. Ус-шлагмын тооцоогоор скруббер шлюзийн баяжмалын баяжуулах ширээнд орох нийт баяжмал нь:

- Бүтээл  $Q = 0.416$  тн/цаг
- Хатуулагийн хэмжээ, 30 %

$$Q = 0.1 \delta_{хүдэр} \left( F \cdot d_{дун} \frac{\delta_{хүнд} - 1}{\delta_{хөн} - 1} \right); \quad Q_{шир} = 10^{-4} \delta_{хүдэр} \left( F \cdot d_{дун} \frac{\delta_{хүнд} - 1000}{\delta_{хөн} - 1000} \right)$$

$\delta_{хүдэр}, \delta_{хүнд}, \delta_{хөн}$  - хүдэр, хүнд, хөнгөн эрдсүүдийн нягт, кг/м<sup>3</sup>

$d_{дун}$  – баяжигдсан бүтээгдэхүүний ширхэглэлийн дундаж хэмжээ, мм

$F$  - тавцангийн талбай, м<sup>2</sup>

*Сэгсрэх ширээний тоог олбол:*


$$n = \frac{Q_T}{Q} = \frac{0.42}{2} = 0.2 \approx 1$$



$Q_{тэж}$  –Тэжээл дэх материалын хэмжээ, т/ц

Дээрх тооцоогоор гарсан үзүүлэлтүүдийг үндэслэн СКО-0.5 маркийн баяжуулах ширээнээс нэг ширхгийг сонгон авлаа. Сэгсрэх ширээний техникийн үзүүлэлтийг доорх хүснэгтэд үзүүлэв.


### Хүснэгт 19. Сэгсрэх ширээний техникийн үзүүлэлт

Д/д	Сэгсрэх ширээний марк	СКО-0.5	
1	Ашигтай талбай, м <sup>2</sup>	8.1	
2	Тэжээлийн ширхэглэлийн хэмжээ, мм	-2	
3	Усны зарцуулалт, тн/цаг	0.4-0.7	
4	Хүчин чадал, тн/цаг	0.5-2	
5	Тэжээлийн хатуугын агуулга, %	10-30	
6	Ширээний налуу, градус	2-8	
7	Цахилгаан хөдөлгүүрийн чадал, кВт	1.7	
8	Ашиглагдах тоо, ширхэг	1	

### Хүрдэн шигшүүр

Шлюзийн баяжмалыг -2 мм тортой хүрдэн шигшүүрээр ангилна. шигшүүрийн доод бүтээгдэхүүнийг сэгсрэх ширээгээр баяжуулна. Дээд бүтээгдэхүүнийг лоткигоор ялгана.

### Хүснэгт 20. Хүрдэн шигшүүрийн техникийн үзүүлэлт

Д/д	Жижиг хүрдэн шигшүүрийн марк	YTS-600	
1	Торны тоо, ш	YTS-600	
2	Торны нүхний хэмжээ, мм	1-3	
3	Хэмжээ, мм	1-10 мм	
4	Налуу, градус	5400*1150*1200	
5	Хүчин чадал, тн/цаг	7	
6	Ажиллагааны давтамж, эрг/мин	1-10	
7	Цахилгаан хөдөлгүүрийн чадал, кВт	20	
8	Торны нүхний хэмжээ, мм	1	


### Ус хангамжийн төхөөрөмжүүд

Баяжуулах цехийн усан хангамжийн хэсэгт технологийн ус болон шаардлагатай цэвэр усыг шахах насосуудыг ашиглана.


### Хүснэгт 21 Технологийн ус шахах насосын техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Технологийн усны насос
1	Марк	K300
2	Хүчин чадал, м <sup>3</sup> /цаг	300
3	Өргөлт, м	50
4	Эргэлт, эрг/мин	1450
5	Хөдөлгүүрийн чадал, кВт	55




6	Тоо ширхэг, ш	1	
---	---------------	---	---

**Хүснэгт 22. Цэвэр ус шахах насосын техникийн үзүүлэлт**

Д/д	Үзүүлэлт	Тоо хэмжээ	
1	Марк	ЭЦВ12-250-105	
2	Хүчин чадал, м <sup>3</sup> /цаг	250	
3	Өргөлт, м	25	
4	Эргэлт, эрг/мин	1450	
5	Хөдөлгүүрийн чадал, кВт	55	
6	Тоо ширхэг, ш	1	

**Хүснэгт 23. Элс угаан баяжуулах үйлдвэрийн нийт тоног төхөөрөмжийн жагсаалт**

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлтүүд		
		Марк	Техникийн үзүүлэлтүүд	Ажиллах тоо /ш/
1	Скруббер	40	Q=40 м3/цаг	1
2	Баяжуулах ширээ	СКО-0.5	Q=2 тн/цаг	1
3	Хүрдэн шигшүүр	УТС-600	Q=1-10 тн/цаг	1
4	Технологийн усны насос	К200	300 м3/цаг	1
5	Цэвэр усны насос	ЭЦВ12-250-105	250 м3/цаг	1
Нийт				5



Зураг -6. Угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмж холболтын схем

#### Хүснэгт 24. Тоног төхөөрөмжийн тайлбар

Д/д	Нэр	Тоо, ширхэг
1	Элсний овоолго	-
2	Экскаватор	-
3	Бункер	1
4	Угаах төхөөрөмж	1
5	Галийн овоолго	-
6	Нам дүүргэлтийн шлюз	2
7	Хүрдэн шигшүүр	1
8	Сэгсрэх ширээ	1
9	Шлихийн алт	-
10	Тунаах нуур	
11	Эргэлтийн усан сан	
12	Насос	
13	Цэвэр ус	

#### 4.10. Баяжуулах цехд тавигдах шаардлага

УУХҮ-ийн сайдын 2019.10.17-ны А/205 тушаалаар батлагдсан “Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ийн хүрээнд дараах ажлууд хийгднэ.



**Хүснэгт 25. Журмын хүрээнд хийгдэх ажлууд**

№	Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын хүрээнд хийгдэх ажлууд:	Хариуцах албан тушаалтан
<b>Баяжуулах цехд тавигдах шаардлага</b>		
1	Баяжуулах цех нь ус зөвшөөрөлтэй байх	
2	Үйлдвэрийн хаяг, байршлын ерөнхий зураг байршуулах	Баяжуулалтын инженер
3	Баяжуулах цехийн хаягдлын аж ахуйн зураг төсөл	Хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх
4	Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө	Хөдөлмөр хамгааллын инженер
5	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, сургалтын бүртгэл хийж байх	Хөдөлмөр хамгааллын инженер
6	Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны тайлан төлөвлөгөө болон тайлан сар, улирал, долоо хоногийн мэдээ гаргаж байх	Баяжуулалтын инженер
7	Технологийн заавартай байх	Баяжуулалтын инженер боловсруулж уурхайн даргаар баталгаажуулах
8	Тоног төхөөрөмжийн ашиглалт паспорт хөтлөх (скруббер, насос, тунаах машин, сэгсрэх ширээ)	Баяжуулалтын инженер
9	Баяжуулах үйлдвэрийн ажилчдын судалгаа хийх	Хүний нөөц
10	Баяжуулах технологийн өдөр тутмын хаяналтын бүртгэл хөтлөх	Баяжуулалтын инженер
<b>Баяжуулах цехийн технологийн хяналт, сорьцлолт</b>		
1	Технологийн дотоод сорьцлолтыг тогтмол хийх	Баяжуулалтын инженер
2	Хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар технологийн сорьцлолтыг жилд 1 удаа хийж гүйцэтгүүлэх	Хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх

**4.11. Баяжуулах цехд тавигдах аюулгүй ажиллагааны дүрэм**

Уул Уурхайн, Хүнд Үйлдвэрийн сайд Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн Дугаар А/155, А/132 “Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг шинэчлэн батлах тухай” хамтарсан тушаалийг баримтална. Дараах хүснэгтэд заасан заалтуудын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө болон арга хэмжээг тус уурхайн хөдөлмөр хамгааллын инженер боловсруулж уурхайн даргаар батлуулна. Тус зардлыг хөдөлмөр хамгааллын зардалд тусгасан болно.

**Хүснэгт 26. Баяжуулах цехийн аюулгүй ажиллагааны баримтлах заалтууд**

Баянхонгор, Өвөрхангай аймгийн Өлзийт, Нарийнтээл сумдын нутагт орших Үзүүрт талбайн “Жалга-2”, “Жалга-3” алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл





№	Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагаан дүрмийн хүрээнд баримтлах заалтууд:
1	Дүрмийг хэрэглэх хүрээ, нийтлэг зүйл
2	Аюулгүй ажиллагааны нийтлэг шаардлага
3	Аюулгүй ажиллагаа
3.1	Аюулгүй ажиллагааны тэмдэг, дохио, хаалт хашилт
3.2	Цахилгааны аюулгүй байдал
3.3	Аюулын үед хэрэгжүүлэх арга хэмжээ
3.4	Ажлын байрны үзлэг шалгалт
3.5	Тоног төхөөрөмжийн тусгаарлалт
3.6	Засварын ажил
3.7	Гэрэлтүүлэг
4	Материал хүлээн авалт
5	Шороон ордын баяжуулалт
6	Хаягдлын сан ба усан сан
7	Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний сорьцлолт, савлалтад тавих шаардлага

## БҮЛЭГ V. ИЛ УУРХАЙН ДЭД БҮТЭЦ

### 5.1 Ил уурхайн цахилгаан хангамж

Цахилгаан хангамжийг одоо ашиглаж байгаа дизель генератороор хангахаар төсөл захиалагчийн өгсөн даалгаврын дагуу тооцоо хийсэн.

Орд ашиглалтын үед цахилгааны гурван хэрэглэгч байна. Үүнд:

- Уурхайн хотхон, гэрэлтүүлэг
- Засварын газар
- Элс угаан баяжуулах цех

Үйлдвэрийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хувийн дизель генератораар хангахаар тооцоолсон бөгөөд уурхайн хотхон, засварын цех, угаан баяжуулах үйлдвэрт нийт 195 кВт цахилгаан зарцуулахаар байна. Иймд дараах ашиглагдаж байгаа дизель генератор хүчин чадал хангалттай байна.

Тооцооны суурь чадлаар дараах үзүүлэлт бүхий дизель генераторыг үргэлжлүүлэн ашиглахаар тусгалаа. Үүнд: Элс угаан баяжуулах хэсэгт Denyo DCA- 220SPK3 маркын 220 кВт-ийн дизель генератор, уурхайн хотхон, засварын цехийн хэрэглээнд 125 кВт – ийн хүчин чадалтай дизель генератор тус тус 1 ширхэг ажиллах юм.




**Хүснэгт 27. Уурхайн тосгон, засварын цехийн дизель генератор**

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Үзүүлэлт
1	Генераторын марк	-	DCA-180SPK3
2	Цахилгаан чадал	кВт	125
3	Цахилгаан чадал	кВА	150
4	Хөдөлгүүрийн марк	-	SA6D108E-2-A
5	Хүчдэл	В	230/400
6	Түлшний зарцуулалт, 80% ачаалалтай	л/цаг	22.4
7	Хэмжээ(урт,өргөн,өндөр)	см	3300x1200x1500
8	Жин	кг	2900
9	Ашиглагдах тоо	ширхэг	2



**Хүснэгт 28. Угаан баяжуулах хэсгийн дизель генератор**

№	Модель	Denyo DCA-220SPK3
1	Хамгийн их цахилгаан, кВА/кВт	220
2	Хэвийн чадал, кВА/кВт	200
3	Моторын загвар	KOMATSU
4	Фазын тоо	3
5	Түлшний багтаамж, л	380
6	Түлшний зарцуулалт /ачаалал 100%/, л/цаг	42
7	Түлшний зарцуулалт /ачаалал 75%/, л/цаг	31.5
8	Түлшний зарцуулалт /ачаалал 50%/, л/цаг	21
9	Өргөн, мм	1300
10	Урт, мм	3650
11	Өндөр, мм	1750
12	Жин, кг	3670
13	Тоо, ш	1



Зураг-14. Цахилгааны ерөнхий схем



## **5.2 Уурхайн тосгон**

Уурхайн хотхоныг “Жалга-2” алтны шороон ордын зүүн урд хэсэгт 500 м зайд 1га талбайд байгуулна. Хотхон ажилчдын амьдрах байр болох 4 ш, 40 тн контейнер сууц, захиргааны байр ажилчдын цайны газрын байр болон угаалгын газраас бүрдэнэ.

Засварын талбайг уурхайн хотхоны залгаа талбайд байгуулна. Талбайд сэлбэг, материалын агуулах, шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг байрлуулна. Засварын талбайн дэргэд шатахуун түгээгүүрийг байрлуулна.

Сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн түр агуулахыг 40 тн-ийн багтаамжтай контейнер ашиглан байгуулна. Жижиг эд анги хэрэгслийн хэмжээнээс хамаарч 1 ширхэг контейнер суурилуулна.

Шатах тослох материалын агуулах нь торон хашаагаар хүрээлэгдсэн задгай талбайд үйлдвэрлэлийн цогцолбороос 150 метрээс доошгүй зайд байрлана. Энд 100-200 литрийн багтаамжтай төмөр торхтой тосолгооны материал, масло болон уурхайн 7-10 хоногийн ажлыг хангах хэрэгцээний түлшний 25 тн багтаамж бүхий ёмкость байрлана.

## **5.4.Гадаргын уснаас уурхайг хамгаалах ажил**

Уурхайн талбайд үер борооны ус орж ирэхээс хамгаалан 0.5 км урттай хамгаалалтын суваг байгуулж уг сувгийг эргэлтийн усан сангийн далантай холбож өгнө.

Уурхайн шүүрэлтийн усыг уурхайн доод төвшинд зумфэд цуглуулж шаардлагатай тохиолдлуудад насосоор шахан эргэлтийн усан сан руу зайлуулна.

## **5.5.Уурхайн зам**

Авто замын байгууламжийг замын барилгын нормын дагуу хийнэ. Ил уурхайн автозамын байгууламж, дээд хучилт, замын өргөн налуу зэргийг төсөлд тодорхой тусгав. Авто замын суурийг тогтвортой хатуу чулуулгаар хийнэ. Ил уурхайн авто замын налуу нь техник эдийн засгийн тооцоогоор, хөдөлгөөний аюулгүй байдал, техник ашиглалтын дүрэм, зааврын шаардлагыг хангасан байхаар тогтоогдсон байна

## **5.6.Үйлдвэрлэл, ахуйн хог хаягдал**

Зөвхөн уурхайд ажиллагсдын ахуйн хуурай хог хаягдал гарна. Хуурай хог хаягдлын тусгай талбай, сав бий болгож, тагтай битүүмжлэл сайн байлгах шаардлагатай бөгөөд дүүрсэн үед нь хогийн нэгдсэн цэгт зөөвөрлөж зайлуулна.

Ажиллагсдын бие засах, усанд орох газар, нийтийн хоолны цэгээс гарах шингэн хаягдлыг тусгайлан, стандарт шаардлагын дагуу байгуулна. Ахуйн хог хаягдлыг органик болон синтезийн гарал үүслээр нь ангилах ба биологийн хог хаягдлыг тусгайлан бэлтгэсэн нүхэнд хийж булах бөгөөд синтезийн буюу полимер нэгдэл бүхий хуванцар сав, гялгар хүүдий зэргийг нэг цэгт цуглуулан технологийн дагуу устгал хийнэ гэж тооцсон.



Машин механизм, хүний нөлөөгөөр бохирдсон шингэн хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт тушаана.

## **БҮЛЭГ VI. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ**

### **6.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй**

Уурхайн бүх үйл ажиллагаа нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн дагуу явагдах бөгөөд түүнийг хатуу чанд мөрдөн, доорх тусгай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсний үр дүнд үйлдвэрийн үйл ажиллагаа хангагдах ёстой. Төсөл боловсруулагч талаас төсөл захиалагчид “MNS OHSAS 18001:2012 ХАБЭА-н удирдлагын тогтолцоо Шаардлага” стандартыг удирдлагын тогтолцоондоо нэвтрүүлж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг зөвлөмж болгож байна. Тухайн стандартын 4.3.1 заалтын дагуу /ажлын байрны зохион байгуулалт, үйл явц, угсралтын ажил, машин тоног төхөөрөмж, үйл ажиллагааны журам, ажлын зохион байгуулалт ба тэдгээрийг хүний боломжинд дасган нийцүүлсэн байдал/ мөн тусгасан заалтуудыг мөрдлөгө болгон ажиллах шаардлагатай.

- Уурхайн хажуу догол ба овоолгын тогтворжилтыг хангах
- Үйлдвэрийн осол гэмтэлтэй тэмцэх арга хэмжээ
- Уурхайн тоосжилттой тэмцэх арга хэмжээ
- Засвар механикийн цехийн аюулгүй ажиллагаа г.м

**Ил уурхайн хажуу догол ба овоолгын тогтворжилтыг хангахын тулд дараах арга хэмжээг авч явуулна. Үүнд:**

- Доголын болон овоолгын нурж болзошгүй хэсгүүдийг цаг тухайд нь унагаж байхын зэрэгцээ нурах болон гулсаж болзошгүй газруудад анхааруулах тэмдэг хадсан байх;
- Уурхайн догол, овоолгын стандарт хэмжээсүүдийг дагаж мөрдөх;
- Уурхайг хур тунадасны уснаас хамгаалан ус орж ирэх бүх талаар нь усны шуудууг татаж хамгаалсан байх.

### **Үйлдвэрийн осол гэмтэлтэй тэмцэх арга хэмжээ**

Үйлдвэр осол гэмтэл нь техникийн, зохион байгуулалтын, сэтгэл зүй физиологийн гэсэн 3 бүлэг шалтганаас гардаг.

- Техникийн шалтгаан. Техник тоног төхөөрөмжийн бүрэн бус байдал, эвдрэл, зохиомжийн тал, технологийн процессыг гүйцэд судлаагүй, төслийн шийдэл үйлдвэрлэлийн ажлын нөхцөлтэй уялдахгүй байх, эвдрэл, ослын эсрэг хамгаалалтын хэрэгсэл, дохиолол холбооны хэрэгсэл байхгүй, хүнд хүчир ажлыг механикжуулаагүй аюултай үйл ажиллагааг автоматжуулаагүй зэрэг хамрагдана.



- Зохион байгуулалтын шалтгаан. Үйлдвэрлэлийн технологи зөрчсөн шалтгаанууд, хүний хүчин зүйлийн, хөдөлмөрийн сахилга бат зөрчсөн, ажил гүйцэтгэгчийн болгоомжгүй үйлдэл, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангахад тавих хяналт сул, технологи төслийн баримт бичгийн шаардлагаас гажих, техник төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээний журмыг зөрчсөн, төлөвлөсөн хугацаанд засварыг хийгээгүй, түүхий эд, тоног төхөөрөмж, материалын чанарын хяналт шалгат төсөлд нийцээгүй материалыг тоног төхөөрөмжүүдэд хэрэгэлсэнээс, үйлдвэрлэлийн хяналт шалгалт хангалтгүй, амгаалах, дохиолол холбооны хэрэгслийг санаатайгаар салгах, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны шаардлагын мэдлэгийн түвшин доогуур, үйлдвэрлэлийн сахилга бат зөрчих, ажил гүйцэтгэгчдийн болгоомжгүй үйлдэл зэрэг багтана.
- Сэтгэл зүй физиологийн шалтгаан. Биеийн хүчний болон мэдрэл сэтгэхүйн хэт ачаалалд орсноос, тухайлбал хүнд ажлын улмаас эсвэл хөдөлмөрийн нэгэн хэвийн байдал, сэтгэл хөдлөл, сонсох харах, мэдрэхүйн эрхтний хэт ачааллын улмаас өвчлөх, буруу үйлдэл хийж алдаа гаргаснаас осолд орох явдал зэрэг орно.

**Иймд үйлдвэрлэлийн осол гэмтэлийг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авч явуулна. Үүнд:**

- Үйлдвэрийн ажил явуулах явцад техник аюулгүй ажиллагааны дүрмийг хатуу мөрдөж, хүн бүрийг аюулгүй ажиллагаанд сургасан байх;
- Уулын ажлыг мэргэжлийн хүний удирдлагын дор явуулна;
- Уулын бүх машин техникүүд нь эмийн сантай байх ба шаардлагатай эмийн зүйлээр хангагдсан байх;
- Бүх техник хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж байх.
- Уурхайн тоосжилттой тэмцэх арга хэмжээ
- Автомашин уурхайгаар явах үед тоос гарна. Үүнээс хамгаалахын тулд дараах арга хэмжээг авч явуулна. Үүнд:
- Тоног төхөөрөмж ажиллаж буй талбай, мөргөцгийг услах;
- Тоног төхөөрөмжийн кабиныг агаар солилцуулах төхөөрөмжөөр тоноглох;
- Ээлж бүрд тоног төхөөрөмжийн кабинд нойтон цэвэрлэгээ хийх;
- Автозам ба овоолгыг байнга услан, засаж, тэгшилж байх

**Засвар механикийн цехийн аюулгүй ажиллагаа**

- Тоног төхөөрөмж, машин механизмын засвар, эд ангиудыг задлах, угсрах ажлыг аюулгүй ажиллагааны карт болон энэхүү зааврын дагуу гүйцэтгэнэ.
- Тоног төхөөрөмжийг бүрэн зогсоож, түүнийг унах, гулсах, хөдлөхөөс хамгаалсан бэхэлгээнүүдийг бүрэн гүйцэд хийсний дараа засварын ажлыг эхлэх хэрэгтэй.





- Засварын үед тоног төхөөрөмжөөс салгаж авсан эд ангиудыг өөр дээр нь тавихыг хориглоно.
- Ажлын байрны шалыг 0.8м-ээс урт иштэй хүрэээр цэвэрлэнэ г.м

### **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

- Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлнэ.
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар мөрдөх дотоод журам боловсруулж хэрэгжүүлнэ.
- Уурхайн хэмжээнд технологийн бүх процессуудыг паспортжуулж, хэрэгжилтийг хянана.
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчлага, ажлын байр бүрийг холбогдох бүх зааварчлагаагаар хангана.
- Галын аюултай тэмцэх бүх талын мэдлэг дадлага эзэмшүүлэх ба бэлтгэлийг иж бүрнээр хангана.
- Шатах тослох материалын хадгалалт байршлыг мөрдөгдөж буй журмын дагуу хангана.
- Барилга объектуудыг галын аюулгүй байдлыг сахих нормативын дагуу байрлуулна.
- Цахилгаан станц бусад хэрэглэгчдийн газардуулгыг зохих тооцооны үндсэн дээр хийнэ.
- Шөнийн цагт ажлын хэвийн байдал аюул осолгүй ажиллагааг хангахын тулд уурхайн мөргөцгүүд, овоолго дээрх ажлын талбай, зам, үйлдвэрийн хэсгийг гэрэлтүүлнэ.
- Ажилчдыг улирлын байдалд тохирох ажлын хамгаалах хэрэгслээр хангана.
- Дүүргийн эмчтэй гэрээ байгуулж үзлэгт тогтмол хамруулах
- Замыг байнга засаж, тоосжилтгүй байлгах арга хэмжээг авна.
- Ажлын байр, зам талбайд ХАА-ны ба замын хөдөлгөөний дүрмийн тэмдэг, дохио санамжуудыг хийж тавих
- Галын онцгой аюултай ажлын байр, техник тоног төхөөрөмжүүдийг ашиглах боломжтой цэнэглэсэн галын хороор байнга хангаж байх
- Тоног төхөөрөмжийн засвар, механизмын туслах чанарын хэрэгслүүд, шахуурга, эрэг эргүүлэгч, салгагч, өрөмдөх болон ирлэх суурь машинуудын үйлчилгээний ажилд 18 нас хүрсэн, тоног төхөөрөмжийг засварлах эрхийн үнэмлэхтэй, засварлах зүйлийнхээ техникийн паспорттай танилцаж энэхүү заавартай танилцаж зааварчлага авсан хүмүүсийг ажиллуулна.
- Тухайн машин механизм, хэрэгслүүд дээр ажиллах хүмүүс нь тэдгээрийн техникийн паспорт, ашиглалтын болон аюулгүй ажиллагааны арга барилын талаар сайтар мэддэг байх ёстой.
- Цахилгаан дамжуулагч бүхий хэрэгсэл (цахилгаан өрөм, эрэг эргүүлэгч механизм) дээр ажиллах хүн цахилгааны мэргэшлийн 2-оос доошгүй



- зэрэгтэй, тоног төхөөрөмжийнхөө техникийн паспорттай сайтар танилцсан, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх ёстой.
- Хэсгийн техникийн хяналтын ажилтнаас (мастер) ажлын даалгавар, аюулгүй ажиллагааны зааварчилга авч зөвхөн ажлын даалгаварт бичигдсэн ажлыг хийж гүйцэтгэнэ.
  - Нэг ажлыг хоёр ба түүнээс дээш хүмүүс хийх бол тэдний нэгийг мастер ахлагчаар томилж, бригадын бусад гишүүд нь түүний удирлагаар ажлыг тодорхой дэс дараатай, харилцан тохиролцсоны үндсэн дээр гүйцэтгэх шаардлагатай.
  - Аливаа ажлыг бүрэн, бүтэн багаж хэрэгслээр, бүрэн, бүтэн тоног төхөөрөмж, механизм дээр гүйцэтгэнэ. Багаж хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах хэрэгтэй.
  - Ажлын явцад тоног төхөөрөмж, машин, механизмд ямар нэг гэмтэл илэрвэл ажлыг тэр даруй зогсоож тоног төхөөрөмж, машин, механизмынхаа асаах хэрэгсэл дээр «ЗАЛГАЖ БОЛОХГҮЙ. ХҮН АЖИЛЛАЖ БАЙНА» гэсэн плакат өлгөж энэ тухай мастерт даруй мэдэгдэнэ. Гэмтлийг бүрэн арилгасны дараа ажлын даалгаврын дагуу ажлаа үргэлжлүүлж болно.
  - Ямар нэгэн осол, золгүй явдал тохиолдсон үед энэхүү газар, байрыг (хүний амь насыг хохироох, технологийн процессыг саатуулах буюу дахин осол гарахааргүй бол) яг тэр хэвээр нь байлгана.
  - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар гарах зардлыг эдийн засгийн бүлгийн үйл ажиллагааны зардалд дэлгэрэнгүй тооцож тусгав. Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын талаарх бүх асуудлыг уурхайн дарга хариуцна.

ХАБЭА-тай холбоотой хууль эрх зүйн орчин, стандарт норм болон төсөл хэрэгжүүлэгч талын ХАБЭА-н бодлого, менежментийн төлөвлөгөө, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж, эрүүл ахуйн шаардлага мөн галын аюулгүй ажиллагаа, аваарь ослын болон онцгой байдалд ажиллах арга хэмжээний талаар тусгаж өгсөн бөгөөд тэдгээрийн зардлын тооцоог оруулсан болно.

## **6.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль эрх зүйн орчин**

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль эрх зүйн орчин менежментийн хөтөлбөрийг хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн тухай, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, гамшгаас хамгаалах тухай, нийгмийн даатгалын тухай гэх мэт хуулиуд болон ХАБЭА-н норм стандартуудыг баримтлан боловсруулж, хэрэгжүүлнэ.



Хүснэгт 29. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын жагсаалт

<b>Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй</b>		
1	ХАБЭА. Нэр томьёо, тодорхойлолт	MNS 4967 : 2000
2	ХАБЭА. Ерөнхий шаардлага	MNS 4968 : 2000
3	ХАБЭА. Сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм	MNS 4969 : 2000
4	ХАБЭА. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага	MNS 4990 : 2000
5	ХАБҮЭА. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ	MNS 5080 : 2001
6	ХАБЭА. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага	MNS 5105 : 2001
7	ХАБҮЭА, Хөдөлмөрийн физиологи, мэдрэл сэтгэхүйн ачааллыг үнэлэх үзүүлэлтүүдийн норм	MNS 5106 : 2001
8	ХАБҮЭА, Хөдөлмөрийн физиологи, биеийн хүчний ажлын ачааллыг үнэлэх үзүүлэлтүүдийн норм тодорхойлох арга	MNS 5107 : 2001
9	ХАБЭА. Ачиж буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 5076 : 2001
10	ХАБЭА. Өргөх зөөх ачааны массын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.	MNS 4970 : 2000
11	Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө	MNS 4643 : 1998
12	Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага	MNS 4931 : 2000
<b>Цахилгаан</b>		
13	ХАБҮЭА. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага	MNS 5150 : 2002
14	ХАБҮЭА. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Нэр томьёо, тодорхойлолт	MNS 5151 : 2002
15	ХАБҮЭА. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Хамгаалах газардуулга тэглэлт	MNS 5146 : 2002
16	Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага	MNS 5390 : 2004
17	ХАБҮЭА. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Хүрэх хүчдэл ба гүйдлийн зөвшөөрөгдөх дээд түвшин	MNS 5145 : 2002
<b>Гал түймэр</b>		
18	Галын аюулгүй байдал. Нэр томьёо ба тодорхойлолт	MNS 0640 : 1989
19	Галын аюултай бүтээгдэхүүний ангилал, зэрэглэл	MNS 4999:2000
20	Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага	MNS 4244 : 1994
21	Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм	MNS 5566 : 2005
22	Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага	MNS 5390 : 2004
23	Шатамхай тосны тэсрэлт. Галын аюулгүй байдал. Ерөнхий техникийн шаардлага.	MNS 0012-105:1994
<b>Хамгаалалтын хувцас</b>		
26	ХАБЭА. Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага	MNS ISO 13688 : 2000
27	Толгой хамгаалах хэрэгсэл, сонсгол хамгаалах хэрэгсэл, /чихэвч, бөглөө/	MNS 5388 : 2004
28	Толгой хамгаалах хэрэгсэл, нүд хамгаалах хэрэгсэл, нүдний шил	MNS 5389 : 2004
29	Толгой хамгаалах хэрэгсэл. Дуулга	MNS 5621 : 2006
30	Толгой хамгаалах хэрэгсэл. Нүүрэвч /химийн хорт бодис, механик биет, дулаан гэрлээс хамгаалах нүүрэвч/	MNS 5624 : 2006
31	Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл /хошуувч, шүүлтүүртэй баг, тусгаарласан агаартай бүтэн баг/	MNS 5620 : 2006
32	Гарын хамгаалалт бээлий. Ерөнхий шаардлага	MNS 5622 : 2011
33	Хөлний хамгаалалт. Ажлын тусгай гутал	MNS 5623 : 2006
<b>Агаар, гэрэлтүүлэг</b>		
34	ХАБЭА. Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага.	MNS 4996 : 2001



35	Ажлын байрны агаар, ажлын байрны агаарын урсгалын хурдыг хэмжих.	MNS 5077 : 2001
36	ХАБЭА. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага.	MNS 510 : 2001
<b>Дуу шуугиан</b>		
37	ХАБЭА. Ажлын байрны шуугиан, норм аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 5002 : 2000
38	ХАБЭА. Шуугианыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага	MNS 5003 : 2000
39	Хэт өндөр дуу, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага,	MNS 12.1.016-88
<b>Доргио, чичиргээ</b>		
40	ХАБЭА. Ажлын байрны доргионы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 4994 : 2000
41	ХАБЭА. Доргионыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага	MNS 4995 : 2000

### 6.3 MNS ISO OHSAS 18001:2012 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандартын хэрэглээ

Аж үйлдвэрлэлт, инженерчлэлийн эрин үед хүн хөдөлмөр эрхлэхдээ эрүүл аюулгүй нөхцөлд осол эндэгдэлгүй ажиллаж, амьдралын чанараа дээшлүүлэх бодит хэмжүүрийн нэг нь ХЭМАБ –ын удирдлагын “зөв” тогтолцоо юм.

Хөдөлмөрийн эрүүл мэнд гэдэг нь хүн хөдөлмөрлөх явцад физик, хими, биологийн хүчин зүйлээс шалтгаалан бие махбод мэдрэл, сэтгэхүйд өөрлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа юм. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа бол, хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхгүй байх нөхцөлийг бүрдүүлдэг.



Зураг-7. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо



MNS ISO OHSAS 18001:2012 стандартын загвар нь Төлөвлө-Хий-Шалга-Сайжруул (PDCA) гэсэн аргачлалд суурилсан бөгөөд бусад удирдлагын тогтолцоонуудтай хослуульж хэрэглэх нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх зориулалтуудаа биелүүлэхэд нь тусалж чадах байдлаар боловсруулагдсан стандарт юм.

## БҮЛЭГ VII. БАЙГАЛЬ ОРЧИН, ЭКОЛОГИЙН ҮНЭЛГЭЭ

Байгаль орчны энэхүү хэсэгт Хужиртын алтны шороон ордын үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах хамгаалах төлөвлөгөө болон уурхайн хаалт нөхөн сэргээлтийн ажлаар хийгдэх ажлын хэмжээ, зардлын тооцоог оруулсан болно.

**Байгаль орчныг хамгаалах удирдлагын тогтолцоо:** Байгаль орчныг хамгаалах удирдлагын тогтолцооны гол зорилго нь төслөөс байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан илрүүлж түүнээс урьдчилсан сэргийлэх, бууруулах ба хянахад чиглэсэн байна. Байгаль орчны удирдлагын тогтолцоог байгаль орчны бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт шалгалт хийх, удирдлагын дүн шинжилгээ хийх гэсэн таван үе шаттай хэрэгжүүлэх бөгөөд энэ нь байгаль орчны үзүүлэлтийг тасралтгүй сайжруулж байх ач холбогдолтой.

Байгаль орчны бодлого: Төсөл хэрэгжих нутгийн байгаль орчны төлөв байдал, төслийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзсэн байгаль орчны бодлогыг боловсруулан хууль эрхзүйн болон бусад шаардлагыг тогтоож, түүнийг мөрдөх журам боловсруулан ажиллана.

Байгаль орчны төлөвлөлт: Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг хийж гүйцэтгэж, түүнийг бууруулах арга замыг тодорхойлон байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл болон эрсдлийг бууруулах бодит зорилго, зорилтыг тодорхойлон жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд оруулна. Байгаль орчны зорилго зорилтод хүрэх үүрэг хариуцлагын зохион байгуулалт, хүрэх арга зам, хугацаа, хэрэгжилтийн үе шатанд хүний нөөц, мэргэшсэн, ур чадвар бүхий л асуудлыг төлөвлөнө.

Хэрэгжүүлэлт, гүйцэтгэл: Байгаль орчны зорилго, зорилтод хүрэх төлөвлөгөөт хугацааны дагуу зохион байгуулагдсан бүх л арга хэмжээг цаг алдалгүй хууль эрхзүй орчин болон стандарт норм, бусад шаардлагад нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.

Хяналт шалгалт: Байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнг байгаль орчны хууль эрх зүй, дүрэм журам, стандарт норм, бусад шаардлага, болон төсөл хэрэгжихээс өмнөх байгаль орчны суурь нөхцөлтэй нийцэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийнэ.





## 7.1 Байгаль орчныг хамгаалах хууль эрхзүйн орчин

Тус ордыг ашиглахдаа МУ-ын холбогдох хууль тогтоомж, стандарт нормыг мөрдлөг болгон ажиллах бөгөөд уг төсөлтэй холбоотой байгаль орчны зарим хуулийг жагсаан оруулав.

*Хүснэгт 30. Байгаль орчныг хамгаалах МУ-ын хууль, тогтоомжууд*

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо	Нэмэлт өөрчлөлт орсон
0	Ашигт малтмалын тухай хууль	2012.05.27	
1	Агаарын бохирдлын төлбөрийн тухай	2010-06-24	-
2	Агаарын тухай	2010-06-24	2012-05-27
3	Хог хаягдлын тухай	2003-11-28	2012-05-17
4	Амьтны тухай	2012-05-17	-
6	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай	2006.05.25	2012-05-17
7	Байгалийн ургамлын тухай	1995-04-11	2010.12.09
8	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай	2012-05-17	
9	Байгаль орчны хамгаалах тухай	1995-03-30	2010.07.08
10	Газрын тухай	2002-06-07	2005.07.01
11	Газрын хэвлийн тухай	1988-11-29	1995.04.17
12	Газрын төлбөрийн тухай	1997-04-24	2005.07.01
13	Соёлын тухай	1996-04-11	
14	Соёлын өвийг хамгаалах тухай	2001-06-08	2005.06.02
15	Ургамал хамгааллын тухай	2007-11-15	2011.01.20
16	Усны тухай	2004-04-22	2009.08.25
17	Ус бохирдуулсаны төлбөрийн тухай	2012-05-17	
18	Химийн хорт болон аюултай хорт бодисын тухай	2006-05-22	2011.10.06
19	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	2008-05-22	2011.01.20
20	Гамшгаас хамгаалах тухай	2012.05.17	
21	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай	2012.05.17	
22	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай		

Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн ажилтай холбоотой зарим стандарт нормын жагсаалтыг дараах хүснэгтэд үзүүлэв.



### *Хүснэгт 31. Байгаль орчныг нөхөн сэргээх стандартууд*

Нөхөн сэргээлт		
1	MNS 5914:2008	<i>БО. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт</i>
2	MNS 5915:2008	<i>БО. Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал.</i>
3	MNS 5916:2008	<i>БО. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт</i>
4	MNS 5917:2008	<i>БО. Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага</i>
5	MNS 5918:2008	<i>БО. Эвдэрсэн газрыг дахин ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага</i>
Ус		
6	MNS 4943:2011	<i>Усны чанар. Хаягдал бохир ус</i>
7	MNS 4586:1998	<i>Усын орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага.</i>
8	MNS 3597:1983	<i>БОХ, Усан мандал. Гадаргуугийн ба газрын доорх усыг эрдэс бордооны бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага</i>



9	MNS 3342:1982	<u>БОХ, Усан мандал.</u> Газрын доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага.
10	MNS 6148:2010	<u>Усны чанар.</u> Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
11	MNS 0900:2005	<u>Ундны ус.</u> Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт. 2010 оны 31 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан.
12	MNS 3935:1986	<u>Ахуйн хэрэгцээ, ундны зориулалттай ус.</u> Хээрийн шинжилгээний аргад тавих ерөнхий шаардлага.
<b>Хөрс, ургамал</b>		
13	MNS 3985:1987	<u>Хөрс.</u> Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл.
14	MNS 3474:2003	<u>Ургамал хамгаалал.</u> Нэр томьёо, тодорхойлолт.
15	MNS 3475:2003	<u>Ургамлын хорио цээр.</u> Нэр томьёо, тодорхойлолт.
16	MNS 6147:2010	Байгаль орчны бохирдол, бохирдлын хяналт ба хамгаалалт - Агаар, хөрсөн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
17	MNS 3298:1991	<u>Хөрс.</u> Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага.
18	MNS 5850:2008	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
<b>Агаарын чанар</b>		
19	MNS 4585:2007	<u>Агаарын чанар.</u> Техникийн ерөнхий шаардлага
20	MNS 5885:2008	<u>Агаарт байх бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ.</u> Техникийн ерөнхий шаардлага.
21	MNS 3383:1982	<u>Агаар мандал.</u> Бохирдлын эх үүсвэр. Нэр томьёо, тодорхойлолт.

Техникийн болон биологийн нөхөн сэргээлт нийт 26.02 га талбайд хийгдэнэ.



**"ЖАЛГА-3"- ҮЙН ДАГУУ ЗҮСЭЛТ**  
 МАСШТАБ: ХЭВТЭЭ 1:2000  
 БОСОО 1:100


Таних тэмдэг

	Газрын гадаргуу		Хөрсний гадаад овоолго
	Ил уурхайн хажуу		
	Элс нээгдсэн хэсэг		
	Элс олборлосон хэсэг		


				Ашигт малтмал, газрын тосны газар	"ИМПЕРО МАЙНИНГ" ХХК	
А.туш	Овоо нэр	Г.үсэг	Огноо			
Захирал	Б.Батцэцэг			Хэлтэс		
Уул.инж	Ч.Болдбаатар			Уулын хэлтэс		
				Х 1:2000		
				Б 1:100		
				Зураг 5.2		
				Нийт зураг 11		
Уурхайн дагуу зүсэлт				Үзүүрт уурхай		

Өвөрхангай аймгийн Нарийнтээл,  
 Баянхонгор аймгийн Өлзийт сумдын  
 нутагт байрлах "Үзүүрт" нэртэй талбайн  
 Жалга-2, Жалга-3 алтны шороон ордын  
 2023 оны ашиглалтын үйл ажиллагааны  
 төлөвлөгөө


18-Р ХАЙГУУЛЫН ШУГАМЫН ЗҮСЭЛТ  
 ХЭВТЭЭ 1:1000  
 БОСОО 1:100




22-Р ХАЙГУУЛЫН ШУГАМЫН ЗҮСЭЛТ  
 ХЭВТЭЭ 1:1000  
 БОСОО 1:100




26-Р ХАЙГУУЛЫН ШУГАМЫН ЗҮСЭЛТ  
 ХЭВТЭЭ 1:1000  
 БОСОО 1:100




02-Р ХАЙГУУЛЫН ШУГАМЫН ЗҮСЭЛТ  
 ХЭВТЭЭ 1:1000  
 БОСОО 1:100







2-Р ХАЙГУУЛЫН ШУГАМЫН ЗҮСЭЛТ  
 ХЭВТЭЭ 1:1000  
 БОСОО 1:100



6-Р ХАЙГУУЛЫН ШУГАМЫН ЗҮСЭЛТ  
 ХЭВТЭЭ 1:1000  
 БОСОО 1:100



Таних тэмдэг

-  Газрын гадаргуу
-  Ил уурхайн хажуу
-  Элсний давхарга
-  Хөрсний дотоод овоолго

				Ашигт малтмал, газрын тосны газар		"ИМПЕРО МАЙНИНГ" ХХК	
А.туш	Овог нэр	Г.үсэг	Огноо			Хэлтэс	Масштаб
Захирал	Б.Батцэцэг			Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Балхангор аймгийн Өлзийт сумдын нутагт байрлах "Үзүүрт" нэртэй талбайн Жалга-2, Жалга-3 алтны шороон ордын 2023 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө		Уулын хэлтэс	X 1:1000 Б 1:100
Уул.инж	Ч.Болдбаатар					Зураг 5.1	Нийт зураг 11
				Уурхайн хөндлөн зүсэлт		Үзүүрт уурхай	